ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ЛХАМСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хот байгуулалт, хотын стандартын газар

Нэгжийн нэр: Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь)	62

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ		15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	
2.	Удирдан зохион байгуулах	
3.	Асуудал шийдвэрлэх	
4.	Манлайлах	
5.	Багаар ажиллах	
6.	Харилцаа	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)*	62
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)*	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)*	15
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)*	—

Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	"92"

Үнэлгээ өгсөн: ***Төсвийн шууд захирагч***

....
(албан тушаал) *(гарын үсэг)* /Г.БАЯРСАЙХАН/
(албан хаагчийн нэр)
2025.12.15 *(огноо)*

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: ***Нэгжийн дарга:***

....
(албан тушаал) *(гарын үсэг)* /Ц.ЛХАМСҮРЭН./
(албан хаагчийн нэр)
2025.12.15 *(огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дүгээр хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Д/д	*Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж*	*Төсөв (Сая төгрөг)*	*Шалгуур Үзүүлэлт*	*Суурь түвшин*	*Зорилтот түвшин*		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	*Гүйцэтгэл хувь*
					Эхний хагас жил	*Сүүлийн хагас жил*		
1	2	3	4	5	6	7	8	9
	ЗОРИЛГО 1. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД							
	Зорилт 1.1. Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км урт Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГУАХ- 1.1.5.3, НЗДУАХ-1)*							
1	1.1.1. Метро төслийн трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 411 дүгээр тогтоолоор, Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 484 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай захирамжаар “Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн тээврийн хэрэгсэл “Метро”-г 2024-2028 онд багтаан барьж байгуулахаар тогтон төсөвт өртөг, санхүүжилтийг баталсан. 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн 8 дугаар хурлаар Их багтаамжийн нийтийн тээвэр /Метро/ хэлэлцүүлэгдэн дэмжигдэж 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр загвар зураг батлагдсан. Улаанбаатар метро төсөл нь Толгойтоос Амгалан хүртэл Энх тайвны өргөн чөлөө дагуу	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							19.4 км урт, 15 өртөө, 1 депо бүхий, цагт 17,200 орчим зорчигч тээвэрлэх хүчин чадалтай төлөвлөгдсөн ба Хот байгуулалтын мэдээллийн санд Метроны шугамын трассыг байршуулсан. Метро төслийн трасс дагуу төлөвлөсөн 15 буудлын инженерийн шугам сүлжээний давхцалыг мэдээллийн сантай тулган төслийн багт тухай бүр тодруулга өгч ажилласан.	
	Зорилт 1.2. Буянт-Ухаа спорт цогцолбороос 120 мянгатын уулзвар, Сүхбаатарын талбай хүртэл 13.1 км урттай болон Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруу Намъянжүгийн гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урттай “Тусгай замын автобус” /BRT/ төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГУАХ- 1.1.5.3, НЗДУАХ-2)*							
2	1.2.1. Тусгай замын автобусны трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Трассын судалгаа хийгдсэн	50	50	Нийслэл Улаанбаатар хотод олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл “Нийслэл Улаанбаатар хотын тусгай замын автобус” BRT төслийн төлөвлөлтийг Хот байгуулалтын асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 53 дугаар хурлаар танилцуулсан. Азийн хөгжлийн банкны 74.7 сая USD-ын энгийн зээлийн санхүүжилтээр хэрэгжих Тусгай замын автобус BRT төсөл нь Улсын гуравдугаар төв эмнэлэгийн баруун тал Ард аюушийн өргөн чөлөө, Л.Энэбишийн өргөн чөлөө, Их тойруу, Намьяанжүний гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөөг хамарч, трассын урт-12.9 км, зогсоол-19ш, нэгдүгээр эгнээний энгийн зогсоол/саравч-5ш, зорчигчийн тоо 25,000-30,000 хүн/өдөр байх ба 2025-	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							2030 онд төслийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн байна. Нийслэлийн Засаг даргын А/652 захирамжийн хүрээнд төслийн трассын дагуух инженерийн шугам сүлжээний тодруулга болон зогсоолын хэсэгт давхцаж буй зөөж шилжүүлэх инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан хангагч байгууллагуудтай зөвшилцөж танилцуулах материал бэлтгэн Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ийн Автобусны тусгай замын төслийн нэгжид хүргүүлсэн.	
	Зорилт 1.3. Зунжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай хүртэл 20.4 км урт “Улаанбаатар хөнгөн галт тэрэг” төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(НЗДҮАХ-3)*							
3	1.3.1. Хөнгөн галт тэрэг төслийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Трассын судалгаа хийгдсэн.	50	50	“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-аас ирүүлсэн архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах тухай хүсэлтийн дагуу Монгол Улсын сайд 20 минутын хот Үндэсний хорооны даргын А/10 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370, А/1553 дугаар “Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх төсөл”-ийн Техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг, төсөв боловсруулах, захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ хүрээнд:	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							➢ Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох – 10.8 км урт хойд трассын дагуу 2025 оны 02 сарын 27-ны өдрийн МЗХ2025/00-214 дугаартай зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлагдсан бөгөөд замын ус зайлуулах байгууламжийн хэсэгт санал өгч ажилласан. ➢ Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд – 15.3 км урт урд трассын дагуу 2025 оны 02 сарын 28-ны өдрийн 2025/00-219 дугаартай гол гудамж замын ангиллын авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар тус тус батлагдан захиалагч байгууллагад хүргүүлсэн. ➢ Батлагдсан ажлын даалгаврын дагуу загвар зургийн Хот байгуулалтын асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн загвар зургийг 2025 оын 04 дугаар сарын 22 өдөр Ерөнхий архитекторын ажлын албаар батлуулсан байна.	
	Зорилт 1.4. Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Агаарын дүүжин замын тээвэр” Төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-4)*							
4	1.4.2. Төслийн 1-р шугам буюу "Яармаг, Арцат-Өнөр хороолол" шугамын ажилд санал өгч, зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	ТЭЗҮ батлуулсан.	50	50	2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 2025/00-164 дугаартай Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврыг Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							нэгж УТҮГ-ын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/101 дугаартай албан бичгийг үндэслэн ХУД-ийн 23 хороо Яармаг "Арцат" буудлаас БГД-ийн 29 хороо, Хархорин худалдааны төвийн автобусны буудал (өнөр хороолол) хүртэлх агаарын дүүжин замын 2023 оны 04 сарын 17-ний өдрийн МЗХ2023/09-013 дугаартай даалгаврын Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Яармаг талын зогсоолд өөрчлөлт оруулан 2025.02.14-ний өдрийн 2025/00-164 Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлуулсан.	
	Зорилт 1.5. Туул усан цогцолбор" төслийг хэрэгжүүлэн үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, гадаргын 125'000 м3/хоног хүчин чадалтай эх үүсвэр барих бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.4.7, НЗДҮАХ-7)*							
5	1.5.1. "Туул усан цогцолбор төсөл"-ийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулах, ТЭЗҮ, ажлын зураг төсөл зөвшилцөх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Улсын төсөвт 48,052.3	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Урьдчилсан ТЭЗҮ боловсруулалт хийсэн.	50	50	БОУАӨЯ, Усны газар, Бүгд Найрамдах Энэтхэг улсын KPIL (Kalpataru Projects International Limited) нь урьдчилсан судалгаа, техникийн шийдлийг боловсруулахаар ажиллаж байна. Тус компаний боловсруулсан Туул усан цогцолборын ТЭЗҮ боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцож тусгах саналаа өгч ажилласан. "Туул усан цогцолбор" төслийн ТЭЗҮ-нд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх ажлын хүрээнд НЗДҮА 2024-2028 хөтөлбөрт төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр нийт 2,245,811.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөснөөс 2025 онд ТЭЗҮ, ажлын зураг боловсруулахад 48,052.3 сая төгрөгийн хөрөнгө	100

Д/д	*Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж*	*Төсөв (Сая төгрөг)*	*Шалгуур Үзүүлэлт*	*Суурь түвшин*	*Зорилтот түвшин*		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	*Гүйцэтгэ л хувь*
					Эхний хагас жил	*Сүүлийн хагас жил*		
1	2	3	4	5	6	7	8	9
							оруулалтын саналыг НЗДТГ-т 01/012 дугаар албан бичгээр явуулсан. Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд нийт 112,064.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, үүнээс 2025 онд ТЭЗҮ боловсруулахад 9,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын хэлтэст саналыг боловсруулан 01/486 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	
	Зорилт 1.6. Дулааны II, III цахилгааны станцыг өргөтгөн шинэчлэх, эсхүл дулаан, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгож, нийслэлд шинээр ашиглалтад орох орон сууцны хорооллыг дулаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. *(ЗГҮАХ-1.1.2.6, НЗДҮАХ-8)*							
6	1.6.1. Дулааны II дугаар цахилгаан станцын хүчин чадлыг 300МВт (1 агрегат нь тохируулгын горимд ажиллах хийн генератор бүхий) -аар өргөтгөж, эх үүсвэрийн хүчин чадалыг нэмэгдүүлэх ажлын газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг зөвшилцөх	-	Ажлын зураг зөвшилцөх гүйцэтгэлийн хувь	ТЭЗҮ хийгдсэн.	50	50	Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/55, А/124 дугаартай тушаал захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан Хот байгуулалт, хотын стандартын газар нь нийслэлийн Орон сууцны бодлогын газар, бусад төслийн нэгжүүдтэй хамтран 2035 он хүртэл хэрэгжих төсөл хөтөлбөрт 2029-2032 оны хэрэгжүүлэх дулааны төсөлд дулааны II дугаар цахилгаан станцын хүчин чадлыг 300МВт-аар өргөтгөж эх үүсвэрийн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажилд тусгасан бөгөөд 142,193 айл өрхийн орон сууцны	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							бүтээн байгуулалтад 26.39 их наяд төгрөгний санхүүжилт шаардлагатай тооцоо боловсруулагдсан. Ажлын хэсэг нийт 12 удаа хуралдсан ба тогтмол танилцуулга материал бэлтгэн холбогдох байгууллагуудаар биелэлт тайлан гаргуулж нэгтгэсэн.	
	ЗОРИЛГО 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	УЛААНБААТАР "20 МИНУТЫН ХОТ"							
	Зорилт 2.2. Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулна. *(ЗГҮАХ -1.1.1.1, НХТЖҮЧ- 9.1, НЗДҮАХ-ийн – 1.1.2)*							
7	2.2.1. "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Улсын Их Хуралд өргөн барьж, батлуулах ажлыг зохион байгуулах	Нийслэлийн төсөв 1646.4	Батлагдсан баримт бичгийн тоо	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шийдэл боловсруулсан.	50	50	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдлийг Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-ны инженерүүдтэй хамтран ажиллаж Улсын их хурлаар оруулах бэлтгэл ажилд хамтран ажилласан. Инженерийн шугам сүлжээний салбарын бодлого хариуцсан Эрчим хүчний яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Усны бодлогын газар, УБДС ТӨХК, УБЦТС ТӨХК, УСУГ, ГУББГ ОНААТҮГ зэрэг шугам сүлжээний хангагч байгууллагуудыг оролцуулан 3-н өдрийн хэлэлцүүлэг зохион байгуулж санал, зөвлөмж авч Хот	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							төлөвлөлт судалгааны институтэд хүргүүлж ажилласан.	
8	2.2.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХТСИ-тэй зөвшилцөн хяналт тавьж ажиллах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Нийслэлийн төсөв 597.5	Батлагдсан баримт бичгийн тоо	-	0	0	Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдлийн талаар холбогдох байгууллагуудтай хамтарсан хурлыг зохион байгуулж өгсөн үүрэг даалгавар, саналыг нэгтгэн ажилласан байна. Үүнд: **Цахилгаан, дулаан хангамжийн шугам сүлжээний чиглэлээр** Эрчим хүчний яам, Аж үйлдвэрлэл, эрдэс баялгийн яам, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Дулааны цахилгаан станц-II, III, IV ТӨХК, ОСНААУГ ОНӨААТҮГ, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ **8** байгууллага, **инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, ариутгах татуурга чиглэлээр** Барилга хот байгуулалт, орон сууцжуулалтын яам, Усны газар, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлийн яам, Ус сувгийн удирдах газар, Ус цаг уурын газар, Гео-экологийн хүрээлэн, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Богдхан уулын дархан цаазат газар, , Геодези Усны барилга байгууламжийн газар гэсэн **11** байгууллага, **мэдээлэл**	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							харилцаа холбооны чиглэлээр Цахим хөгжил инновац харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Монголын цахилгаан холбоо ХК, Монгол шуудан ХК **5** байгууллага нийт **24** байгууллага хамтарсан саналыг нэгтгэн Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-д хүргүүлэн ажилласан. Инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ тус бүрийн хөрөнгө оруулалтын тооцооны задаргааг Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-аас авч жишиг үнийг үндэслэн тооцоолол хийсэн эсэхийг нягталж, санал хүргүүлж ажилласан. Эцсийн тайланд хөрөнгө оруулалтын томсгосон тооцоонд Инженер хангамжийн нийт төсөв 41,589.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөн байгаа нь хий хангамж, хог хаягдлын хөрөнгө оруулалтын тооцоо ороогүй дүн байсныг саналд тусган нэмж оруулснаар инженер хангамжийн нийт төсөв 46,576.0 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.	
	Зорилт 2.3. “Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг, салбаруудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. *(ЗГҮАХ -1.1.1.1, НЗДҮАХ-ийн – 1.2.3)*							
9	2.3.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг	Нийслэлийн төсөв 14,390.6	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн даалгаварт санал өгч, шугам сүлжээний одоогийн байдалд үнэлгээ хийж ажилласан. Нийслэлийн Засаг	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
	зөвшилцөн хяналт тавьж ажиллах. (14 хот)						даргын захирамжийн А/548 дугаар захирамжийн хүрээнд 14 хотын инженерийн шугам сүлжээний хүртээмжийн одоогийн байдлын судалгааг гарган, шугам сүлжээний хүртээмжийн үнэлгээ хийсэн. Мөнх танилцуулга бэлтгэн ажлын хэсгийн хуралдаанд танилцуулж, ХТСХ-д хүргүүлсэн. 42 нэгж хороолол, VII дугаар нэгж хорооллын инженерийн шугам сүлжээний одоогийн байдлын үнэлгээний нэгтгэл хийж, танилцуулга (ppt) бэлтгэн Ерөнхий архитектор болон ажлын хэсэгт хүргүүлсэн. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд шаардлагатай нийт 46 төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалтын тооцоог хянаж саналыг Нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. НЗДҮАХ 2024-2028 инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээг задалж, 4 жилээр санхүүжих хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгжилтийн хувийг боловсруулан Захиргаа Удирдлагын хэлтэст хүргүүлсэн.	
10	2.3.3. Агросити дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг	Нийслэлийн төсөв 2,332.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	10	50	50	Агро сити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын инженерийн шугам сүлжээний хэсэгт санал өгч ажилласан. Зөвлөх үйлчилгээний компани Гови трэвил ХХК-ийн	100

Д/д	*Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж*	*Төсөв (Сая төгрөг)*	*Шалгуур Үзүүлэлт*	*Суурь түвшин*	*Зорилтот түвшин*		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	*Гүйцэтгэл хувь*
					Эхний хагас жил	*Сүүлийн хагас жил*		
1	2	3	4	5	6	7	8	9
	зөвшилцөн хяналт тавьж ажиллах.						боловсруулан ирүүлсэн эхлэлийн тайланд санал, зөвлөмж хүргүүлэн ажилласан.	
11	2.3.4. Шаргаморьт дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөн хяналт тавьж ажиллах.	Нийслэлийн төсөв 1,065.8	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	10	50	50	Шаргаморьт дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын инженерийн шугам сүлжээний хэсэгт санал өгч ажилласан.	100
ОЛОН ТӨВТ ХОТ								
Зорилт 2.4. Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна. Нийслэл Улаанбаатар хотод шинээр байгуулах орон нутгийн зэрэглэлтэй Хан-уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 42 хорооллыг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, “Нэг төвт хотоос олон төвт хот”-ын тогтолцоог бүрдүүлнэ. *(НЗДҮАХ-ийн – 1.2.1)*								
12	2.4.1. Сэлбэ дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтийн төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөх, ажлын даалгавар боловсруулах, газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх,	Нийслэлийн төсөв 1,599.0	Батлагдсан баримт бичгийн тоо	ТЭЗҮ, барилгажилтын төсөл	5	5	НИТХ-ын 2023 оны 61 дүгээр тогтоолын хүрээнд Сэлбэ дэд төвийн 158 га талбайд барилгажилтын төсөл, гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянаж зөвшилцөн хангагч байгууллагуудад хандан техникийн нөхцөл шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан. Сэлбэ дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг ББСМО ХХК-аас боловсруулан ирүүлсэн. Тус ажлын зураг төслийг инженерийн дэд бүтцийн чиглэл бүрээр санал өгч хянаж ажилласан. Барилгажилтын төслийн өөрчлөлт бүрийн дэд бүтцийн шийдэлд санал өгч зөвшилцөж ажилласан. **Цахилгаан хангамж:** Сэлбэ дэд төвийн цахилгаан хангамжийн төлөвлөлтийн шийдлийн дагуу Эрчим	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							хүчний яамнаас 45МВА хүчин чадалтай техникийн нөхцөл шийдвэрлэгдсэн. Сэлбэ дэд төвийн цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг мэргэжлийн зөвлөлийн 8 дугаар хурлаар хэлэлцүүлж МЗХ2025/09-001 дугаартай даалгавар батлуулсан. ББСМО ХХК-ийн боловсруулсан цахилгаан хангамжийн ББ-01/2025 шифртэй ажлын зураг төсөл зөвшилцсөн. **Холбоо:** Одоо байгаа Сэлбэ мэдээлэл холбооны нэгдсэн төв сүлжээнээс 4434 айлын орон сууц, үйлчилгээний барилга байгууламж тэжээгдэхээр ажлын зураг төслийг зөвшилцсөн. Тус барилгажилтын төслийг үндэслэн Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ний D-2025/76 тоот техникийн нөхцөл шийдвэрлүүлсэн. **Дулаан хангамж:** Эхний ээлжийн 19.23 Гкал/цаг хүчин чадалтай хэрэглээг одоо байгаа Сэлбэ дулааны станцаас тэжээгдэхээр зөвшилцсөн. **Ус хангамж, ариутгах татуурга:** Сэлбэ дэд төвийн усан хангамжийг нэмэгдүүлэхээр Хайлааст усан санг өргөтгөх 1.0 га, хөв цөөрмийн усыг дахин ашиглах технологийн усны тохируулах усан сан барих 1.0 га, газар эзэмшүүлэх саналыг Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд тусгуулан НИТХ-аар дэмжигдсэн.	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							Инженерийн бэлтгэл арга хэмжээ: 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн МЗХ-ын 12 дугаар хурлаар хөрсний усны түвшин бууруулах, ус зайлуулах байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг хэлэлцүүлэн батлуулж ажилласан. Тухайн ажлын зураг төслийн төлөвлөлтийн шийдэлд гаргах хуралд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд 2 удаа оролцож нэгдсэн шийдлээр зөвшилцөж ажилласан. **Зам:** Сэлбэ дэд төвийн барилгажилтын төсөлд гудамж замын бүтэц болон замын ангилал, зэрэглэл тогтоох болон одоогийн гудамж замын өргөтгөл шинэчлэлтийн талаар санал зөвлөмж өгч барилгажилтын төсөлд тусгуулсан.	
13	2.4.2. Толгойт, Сэлбэ дэд төв орчмын II ээлж, Дамбадаржаа дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөх, ажлын даалгавар боловсруулах, газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх,	-	Батлагдсан баримт бичгийн тоо	НИТХ-ын 2024 оны 107-р тогтоол	5	5	Дамбадаржаа, Толгойт дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцөн хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. “Сэлбэ дэд төв” барилгажилтын төслийн 158 га талбайд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцөж, хотын мэдээллийн санд байршуулсан. **Үүнд:** **Инженерийн бэлтгэл арга хэмжээ:** Дамбадаржаа дэд төвийн хүрээнд МЗХ-ын 07 дугаар хурлаар СБД-ийн 16,18 дугаар хорооны үерийн хамгаалалтын суваг, хөрсний ус зайлуулах байгууламжийн ажлын	5

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							зураг төсөл боловсруулах даалгавар батлуулсан. Сүхбаатар дүүргийн 15,17 дугаар хороонд нарийвчилсан ажлын зураг төсөл дүүргийн хөрөнгөөр хийгдсэн бөгөөд зөвшилцөж мэдээллийн санд тусган ажилласан. **Дулаан хангамж:** Дамбадаржаа дэд төвийн СБД-16.17 шифртэй шугамын өөрчлөлтийн зураг,"Сэлбэ дэд төв" Барилгажилтын төслийн дулаан хангамжийн 1.2 багц ББ-01/2025 шифртэй гадна дулаан хангамжийн ажлын зураг төсөл зөвшилцөж хотын мэдээллийн санд оруулсан. Тус барилгажилтын төслийг үндэслэн Эрчим хүчний яамны Н01/2025 тоот дулаан хангамжийн техникийн нөхцөл гарсан. ХИХУГ-ийн техникийн нөхцлийн хуралд комиссын гишүүнээр оролцсон бөгөөд Ажилчдын түр байрны барилгад 2025 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар 4 ширхэг дулааны техникийн нөхцөл шийдвэрлэгдсэн. **Ус хангамж, ариутгах татуурга:** Шугам сүлжээний ажлын зураг төсөл 4 үе шаттай хийгдсэн. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний техникийн нөхцөлийг гадна шугам сүлжээний ажилд тусад нь олгож, одоо хийгдсэн шугам сүлжээтэй уялдуулж зөвшилцсөн. Трассыг хот байгуулалтын мэдээллийн санд баяжилт хийсэн.	

Д/д	*Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж*	*Төсөв (Сая төгрөг)*	*Шалгуур Үзүүлэлт*	*Суурь түвшин*	*Зорилтот түвшин*		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	*Гүйцэтгэ л хувь*
					Эхний хагас жил	*Сүүлийн хагас жил*		
1	2	3	4	5	6	7	8	9
							Цахилгаан хангамж: Сэлбэ дэд төвийн цахилгаан хангамжийн төлөвлөлтийн шийдлийн дагуу 110/35/10кВ-ын дэд станц болон цахилгаан түгээх сүлжээний ажлын зургийн даалгаврыг мэргэжлийн зөвлөлийн 8 дугаар хурлаар хэлэлцүүлж батлуулсан. **Холбоо:** "Сэлбэ дэд төв" Барилгажилтын төслийн мэдээлэл харилцаа холбооны 1. 2 багц ББ-01/2025 шифртэй гадна холбооны ажлын зураг төсөл зөвшилцөж хотын мэдээллийн санд баяжилт хийсэн. УБХГХХХОДХТ, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Арбэл-Алтай ХХК, ББСМО ХХК-той хамтарсан уулзалт хийж Сэлбэ дэд төвийг Дамбадаржаа дэд төвтэй холбох ажлыг зураг төслийг уялдуулан боловсруулах ажлын хүрээнд төлөвлөлтийн шийдэлд санал солилцож зөвлөмж хүргүүлэн ажлын уялдааг ханган ажилласан. Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд доорх саналыг хүргүүлэн ажилласан. Үүнд: ✓ 3 байршилд усан сан барих, өргөтгөх, /Сэлбэ дэд төвийн усан санг өргөтгөх, тохируулах усан сан барих, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хүрэл тогоотын аманд хувийн хөрөнгөөр усан сан барих /	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							✓ 9 байршилд дэд станц, өртөө барих. /2025 оны төсөвт зураг төсвийн ажил хийгдэхээр тусгагдсан/ ✓ 3 байршилд дулааны эх үүсвэр барих газрыг тусгуулах /Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төв, Шар хад дэд төвийг дулаанаар хангах/.	
14	2.4.3. Дарь-Эх, Монель, Тахилт олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөх, ажлын даалгавар боловсруулах, газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх,	Нийслэлийн төсөв 69,0	Батлагдсан баримт бичгийн тоо	ТЭЗҮ, барилгажилтын төсөл	3	4	Дарь-Эх, Монель, Тахилт олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг 2023 онд зөвшилцсөн. Дарь эх Үерийн хамгаалалтын суваг (Тэгш өнцөгт. хучилттай) 4.8 км/ барьж байгуулахад 5,047.0 сая төгрөгийн төсөвт өртөг, Тахилтын үерийн хамгаалалтын суваг /8.4 км/ барьж байгуулахад 23,930.0 сая төгрөгийн төсөвт өртгийг Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Геодези усны барилга байгууламжийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 342 дугаартай албан бичгийн дагуу Баянзүрх дүүргийн 21,27 дугаар хороо, Дарь эх, ганц худаг орчмын үерийн хамгаалалтын сувгийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг МЗХ-ын 29 дүгээр хурлын шийдвэрээр	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							батлуулан захиалагч ГУББГ, ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.	
Зорилт 2.8. Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт, Шархад, Яармаг дэд төвүүдийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана. *(ЗГҮАХ -1.1.3.1, НЗДҮАХ-ийн – 1.2.5)*								
15	2.8.1. Дамбадаржаа 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцөж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах	Нийслэлийн төсөв 79,000.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	15	50	50	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Дамбадаржаа дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээ, 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Дамбадаржаа дэд төвийн өөрчлөлтийн 140метр гадна дулааны шугам ажлын зураг зөвшилцөж хотын ebarilga.ub.gov.mn мэдээллийн санд оруулсан. Дулааны шугамын угсралтын ажил 100 хувьтай, дэд төвийн барилга угсралтын ажил 7 хувьтай хийгдэж байгаа бөгөөд зуухны сонголтын талаар хэлэлцэгдэж байна. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд 62.1 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэхээр саналыг маягтын дагуу боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01-01/192 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар дэд төвийн барилга угсралтын ажил 45 хувьтай хийгдэж байна.	100
16	2.8.2. Яармаг хотын шинэ төвд 93МВт-ийн дэвшилтэт технологи бүхий дулааны эх үүсвэрийн газар олголтыг шийдвэрлүүлж, ажлын даалгавар боловсруулах,	Нийслэлийн төсөв 750.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	ХЕТ-нд тусгагдсан	50	50	Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/55, А/124 дугаартай тушаал захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг	100

Д/д	*Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж*	*Төсөв (Сая төгрөг)*	*Шалгуур Үзүүлэлт*	*Суурь түвшин*	*Зорилтот түвшин*		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	*Гүйцэтгэл хувь*
					Эхний хагас жил	*Сүүлийн хагас жил*		
1	2	3	4	5	6	7	8	9
	ТЭЗҮ, ажлын зураг төсөл зөвшилцөх,						даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. 2025-2028 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдэд шаардлагатай 93ВМт-ын Яармаг дулааны станц төлөвлөгдсөн. Тус эх үүсвэрийн байршил нь 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/1165 дугаартай албан бичгээр Нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний саналд тусгасан.	
Инженерийн дэд бүтэц								
Зорилт 2.12. Улаанбаатар дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгон тоноглон шинэчлэх, Парк, Дамбадаржаа, Баянхошуу, Их наран дэд станц, 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ. (*НЗДҮАХ-ийн – 1.3.2*)								
17	2.12.1. Дамбадаржаа, Баянхошуу, Их наран, 110/35/10кВ-ын 2*40МВА чадалтай дэд станц, 110кВ-ын ЦДАШ-ын газар олголтыг шийдвэрлэх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Улс, нийслэл 61,429.5	Ажлын зураг зөвшилцөх гүйцэтгэлийн хувь	-	50	50	- Дамбадаржаа дэд төв, Сэлбэ дэд төвийн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд 110/35/10кВ-ын Дамбадаржаа дэд станцын 17,900.0 сая төгрөгийг нийслэлийн төсөвт санал хүргүүлснээс 2025 оны нийслэлийн төсөвт 5,900.0 сая төгрөг батлагдсан бөгөөд дэд станцын газар олголтыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн саналын дагуу өөрчлүүлэх хүсэлтийг Нийслэлийн Газар зохион	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							байгуулалтын албанд хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд ЦДҮС ТӨХК болон ажлын зураг зохиогч Бодит чадал ХХК-ийн төлөөлөлтэй хамтран газар дээр ажиллаж судалгаа хийсэн. 10/35/10кВ-ын Дамбадаржаа дэд станцын гүйцэтгэгчээр ДМТМ ХХК шалгарсан бөгөөд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсан. 110кВ-ын тулгуурын суурийн ажлууд хийгдэж байна. - Баянхошуу дэд станцын ажлын зураг төсөв батлагдсан ба газар олголт шийдвэрлэгдсэн. Баянхошуу орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40кВА чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажилд нийт 15,708.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас Нийслэлийн 2025 оны төсөв, төслийн тодотголд 7,854.4 сая төгрөг тусгуулахаар НЗДТГ-т 01/486 тоот албан бичгээр санал явуулсан - Их наран дэд станцын ажлын зураг төсөв батлагдаж, газар олголт шийдвэрлэгдсэн. Ихнаран орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40кВА чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажилд нийт 27,809.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас Нийслэлийн 2025 оны төсөв, төслийн тодотголд 13,904.7 сая төгрөг тусгуулахаар НЗДТГ-т 01/486 тоот албан бичиг санал явуулсан. Дээрх 2	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							дэд станцын ажлуудад төсвийн шинэчлэл хийлгэхээр 01/482 албан бичгээр Нийслэлийн төсвийн тодотголд санал хүргүүлсэн.	
18	2.12.2. Парк 110/10кВ-ын 2*63МВА чадалтай дэд станц, 110кВ-ын ЦДАШ, ЦДКШ-ын газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх.	Гадаад зээл тумламж 17.0 сая.euro	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 25/48 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвийн хэсгийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах зорилгоор Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн 10.2га талбайд цахилгааны дэд станц өргөтгөн барихтай холбогдуулан Эрчим хүчний яамны харьяа “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн эзэмшиж буй 0.089 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж 0.12 га хэмжээтэйгээр төлөвлөсөн байршилд 110/10кВ-н Парк /Өргөө болж нэр солигдсон/ дэд станцын газрыг шийдвэрлүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Газар эзэмших эрх олгох тухай” А/698 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Эрчим хүч дамжуулах станцын зориулалтаар 1200 м.кв газрыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д олгох шийдвэр гарсан. Дэд станцын 110кВ-ын кабель шугамын трассыг Бохир	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							усны Туул-1 коллекторын трасстай уялдуулж шийдэл гаргахаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК болон зураг төсөл зохиогч Бодит чадал ХХК судалгаа хийж байна.	
19	2.12.3. Шинээр баригдах дэд станцуудын ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төсөл зөвшилцөх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах. /13 багц/	Нийслэлийн төсөв 2,853.6	Ажлын зураг төсөв боловсруулах гүйцэтгэлийн хувь	-	50	50	Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/55, А/124 дугаартай тушаал захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлаар 13 дэд станцын газрын асуудлыг хэлэлцүүлсэн. 2025 оны нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 13 дэд станцын ажлын зураг даалгавар боловсруулан хангагч байгууллагад хүргүүлсэн. Дэд станцын зураг, төсвийн гүйцэтгэгч шалгарсан бөгөөд төлөвлөж буй болон өргөтгөх шаардлагатай дэд станцын газар олголт, цахилгаан түгээх шугамын трассыг чөлөөлүүлэхээр ЦДҮС ТӨХК-тэй хамтарч судалсны дагуу газар олголтыг шийдвэрлүүлэх хүсэлт, Нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулах тухай саналыг 2025 оны 01/1165 дугаартай албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт 2.13. Дулаан хангамжийн гол болон орон сууцны хорооллын төвлөрсөн шугам сүлжээ, насос станцыг өргөтгөн шинэчилж, шинээр барьж хүртээмжийг нэмэгдүүлнэ. *(ЗГУАХ-1.1.2.1, НЗДУАХ-ийн – 1.3.5)*								
20	2.13.1. Дулааны шугамын өөрчлөлт, шинэчлэлтийн ажлын газар олголтыг шийдвэрлүүлэх, шугамыг хот байгуулалтын мэдээллийн санд тусгах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх. /2Ф700/2Ф600/350 мм-ийн голчтой 1.452км шугамын барилга угсралтын ажил хийгдэнэ/.	Улс, нийслэлийн төсөв 9,519.9	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Ажлын зураг төсөлтэй.	50	50	Төвлөрсөн дулааны шугам шинээр татах, шугамын голчийг өргөтгөх ажлын зургийн даалгаварт санал хүргүүлж, төвлөрсөн дулаан хангамжийн шинэчлэлтийн ажлын зураг төсөл зөвшилцсөн. Төвлөрсөн дулааны шугам шинээр татах, шугамын голчийг өргөтгөх ажлын зургын даалгаварт санал хүргүүлж, нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд тусгуулах саналыг 03/15 дугаартай албан бичгээр тусгуулсан. 2025 оны 01/1165 дугаартай албан бичгээр нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн. 1.452 км дулааны шугамын өөрчлөлт, шинэчлэлтийн ажлын тухайд 2025 оны байдлаар Улсын төсөвт 0.722км, 2ф600-2ф700мм-ийн голчтой дулааны шугамын 2,537.65 сая.төгрөг тавигдсан. 2025 оны төсвийн тодотголд төсөв шинэчлүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 01/482 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийнг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний саналд тусгасан.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/1165 дугаартай албан бичгээр Нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан.	
21	2.13.2. Дулааны сүлжээний даралт өргөх насос станц №7-ыг өргөтгөн шинэчлэлтийн ажлын газар олголтыг шийдвэрлүүлэх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Улс, нийслэлийн төсөв 7,500.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Ажлын зураг төсөлтэй.	50	50	Дулааны сүлжээний даралт өргөх насос станц №7-ыг өргөтгөн шинэчлэлтийн ажлын газар олголтыг шийдвэрлүүлж, хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Улсын төсвийн хөрөнгөөр 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. Дулааны сүлжээний даралт өргөх насос станц №7-ыг өргөтгөн шинэчлэх ажил /2022-оны төсөвтэй /нийт 16,827.71 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөвтэй ба НЗДҮАХ 2024-2028 арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд шугам угсралтын ажлын 25%-ийг гүйцэтгэхээр 4,206.9 сая төгрөг тусгуулахаар 01/012 албан бичгээр санал илгээсэн. Санхүүжилт шийдвэрлэгдсэн. Монгол улсын хөгжлийн 2025 оны төсвийн тодотголд 8,427.8 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэх саналыг боловсруулан 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 01/203 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны байдлаар Улсын төсөвт 5.9 тэрбум.төг тавигдсан. Тус ажил нь 2022 оны төсөвтэй бөгөөд Барилга хот, байгуулалтын сайдын 2024 оны 44 дүгээр тушаалын хавсралтаар	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							батлагдсан Барилга байгууламжийн үнийн индекс к-1.85 коэффициентыг ашиглан Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд 4,897.0 сая.төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэхээр санал боловсруулан ажилласан. Хотын мэдээллийн санд байршуулсан. Насос станц №7 барилга угсралтын ажил 2025 оны 11 дугаар сарын 15-ны байдлаар 30 хувьтай хийгдэж байна.	
Зорилт 2.14. Сэлбэ болон Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд хийн түлшний 93МВт хүчин чадал бүхий дулааны станцыг төвлөрсөн сүлжээтэй хосолмол ажиллагаатай нөхцөлөөр ашиглалтад оруулж, орон сууцны 7 дугаар хороолол болон Дэнжийн мянга дэд төвийн дулаан хангамжийг шийдвэрлэнэ. *(ЗГҮАХ-1.1.2.1, НЗДҮАХ-ийн – 1.3.6)*								
22	2.14.1. Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төслийг зөвшилцөх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Нийслэлийн төсөв 104,000.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	ТЭЗҮ, ажлын зураг төсөв батлагдсан.	50	50	Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ажлын зураг төслийг зөвшилцсөн бөгөөд хотын мэдээллийн санд оруулсан. Онцгой байдлын ерөнхий газартай зөвшилцөх шатанд явж байна. Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/55, А/124 дугаартай тушаал захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. 2025-2028 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдэд шаардлагатай 93ВМт-ын Дэнжийн мянга дулааны	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							станц төлөвлөгдсөн. 2025 оны 03 дугаар сарын 21-нд НГЗБА-нд нийт нөлөөлөлд өртсөн өртсөн 84 нэгж талбараар чөлөөлөгдөөгүй 11 нэгж талбарыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Тус эх үүсвэрийн байршил нь 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Дэнжийн мянга дэд төв, Орон сууцны YII хороолол орчмын 8200 айл өрх төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох ач холбогдолтой Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсвэр барьж ашиглалтад оруулахад нийт 79,000.0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатайгаас Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд барилга угсралтын ажлын 25%-ийг гүйцэтгэхээр 19,750.0 сая төгрөг тусгуулахаар НЗДТГ-т 01/012 тоот албан бичгээр санал явуулсан. Нийслэлийн төсвийн тодотголд хөрөнгө оруулалтын төсөвт өртөг 104,000.0 сая төгрөг / Тархмалын төслийн нэгжээс индекс тооцон төсөв нэмэгдэж ирсэн/ шаардлагатайгаас Нийслэлийн төсвийн тодотголд нийт хөрөнгө оруулалтийн төсөвт өртөг 104,000.0 сая төгрөг / болж тархмалын төслийн нэгжээс төсөв нэмэгдэж ирсэн/ шаардлагатайгаас 2025 онд 52,000.0 сая төгрөг тусгуулахаар санал	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							хүргүүлсэн. 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн Дэнжийн мянга дулааны станцын хүрээнд хурал зохион байгуулсан бөгөөд тус хуралд танилцуулга бэлтгэж ажилласан.	
Зорилт 2.15. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн тархмал эх үүсвэр болон алслагдсан суурьшлын бүсүүдэд дулааны станцуудыг үе шаттайгаар барина. *(ЗГҮАХ-1.1.2.1,НЗДҮАХ-ийн – 1.3.7)*								
23	2.15.1. Оргил ачааллын үед төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосломол ажиллагаатай хийн технологи бүхий дулааны эх үүсвэрийн газар олголтыг шийдвэрлүүлэх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах. (4 байршилд 270мВт хүчин чадалтай)	Улс, нийслэлийн төсөв 226,000.0	Ажлын зураг зөвшилцөх гүйцэтгэлийн хувь	ТЭЗҮ батлагдсан.	50	50	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Эрчим хүчний яамнаас оргил ачааллын үед төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай шингэрүүлсэн хийн түлшний технологи бүхий нийт 270 МВт хүчин чадалтай дулааны станцыг 4 байршилд төлөвлөсөн. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 24/26 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 4 байршилд “Хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэр” барих газар олголт тусгагдсан. Нийслэлийн Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний тодотголд оруулахаар саналыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03/15 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн он дамжин хийгдэх ажил тул Нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулах тухай саналыг 2025 оны 01/1165 дугаартай	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
							албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Тус эх үүсвэрийн байршил нь 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 01-04/1811 дугаартай хариу албан бичигт төлөвлөж буй байршлын 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 01-04/1663 дугаар албан бичгээр санал авахаар Байгаль, орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн талаар мэдээлэл ирүүлсэн. Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшинд 2025 оны 1 дүгээр сарын 23-ний өдөр тархмал эх үүсвэрийн 4 байршилд танилцуулга бэлдэж, мэдээлэл хүргүүлсэн. 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн Нийслэлийн засаг даргын А/1215 дугаартай захирамжийн хүрээнд Хан Хиллсын 4га газарт 112МВт-ийн хийн эх үүсвэр баригдахаар төлөвлөсөн.	
	Зорилт 2.16. Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж, дулааны хүчин чадлыг 216 МВт-аар нэмэгдүүлэх төсөлд дэмжлэг үзүүлнэ. *(ЗГҮАХ-1.1.2.10, НЗДҮАХ-ийн – 1.3.8)*							
24	2.16.1. Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж дулааны хүчин чадлыг 116МВт-аар нэмэгдүүлэх ажлын хөрөнгийг	Нийслэлийн төсөв 113.280.0	Саналын тоо	ТЭЗҮ, ажлын зураг төсөл батлагдсан.	1	1	Дулааны эх үүсвэрийн хүчин чадал 100% нэмэгдүүлэх, 23900 айл өрх төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдох боломж бүрдэх ач холбогдол бүхий Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Сая төгрөг)	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Нийслэлийн Засаг даргын “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгах зохион байгуулах тухай” 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/33 дугаар захирамжийн хүрээнд

- Нийслэлийн Засаг даргын “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгах зохион байгуулах тухай” 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/33 дугаар захирамжийн хүрээнд гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад пийшин зуухны галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэх, түүхий нүүрс ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт зохион байгуулан,





судалгаа гаргах, зөвлөгөө зөвлөмж хүргэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ны өдрүүдэд зохион байгуулж Баянзүрх дүүргийн 31 дүгээр хорооны нутаг дэвсгэр Монел-4, Монел-11, Монел-12, Уулын 10, 12 дүгээр хэсгийн айл өрхөөр судалгаанд явсан. Судалгаанд Хэсгийн ахлагч Жаргал, нийслэлийн Онцгой байдлын албан хаагч, хэсгийн цагдаа нарын хамт оролцсон ба нийт 240 айл өрхөөс судалгаа авч ажилласан.

Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Нийслэлийн Засаг даргын "Орчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зохион байгуулах тухай" болон "Эзэнгүй нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газрын ашиглалтын зардлыг шийдвэрлэх тухай" захирамжуудын хүрээнд

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн шуурхай зөвлөгөөнөөр үүрэг болгосны дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт байх эзэнгүй муур, нохой барих, тоог бууруулах арга хэмжээг 2025 оны 4 дугаар сарын 24-25 өдрүүдэд зохион байгуулсан. Үүний хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын албан хаагчид Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд хуваарилагдан ажилласан.

Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/652 тоот захирамжийн хүрээнд

"Тусгай замын автобус" BRT төслийн зээлийн үнэлгээний судалгааны тооцоог хянаж, бусад төсөл хөтөлбөрүүд, хот байгуулалтын үйл ажиллагаатай хэрхэн уялдан хэрэгжихэд үнэлэлт, дүгнэлт өгч, шугам сүлжээний хангагч байгуулгуудаас санал хөрөнгө оруулалтын төсвийн тооцоог гаргах ажлыг зохион байгуулж ажилласан.

БАЙРШЛЫН СХЕМ



	ШУГАМЫН СҮЛЖЭЭНИЙ ХҮЧИН ЧАДАЛ	УРТ /КМ/	ТОО ШИРХЭГ
ИБАХ	300-400 мм	11.27	3 коллектор
ДУЛААН ХАНГАМЖ	2ф150,200,250,300, 350,400,500,800мм	0.177	21
УС ХАНГАМЖ	Ф150,200,300, 400,500мм	0.152	19
АРИУТГАХ ТАТУУРГА	Ф300,400, 600мм	1.22	34
ЦАХИЛГААН ХАНГАМЖ	0.4-110кВ-ын ЦДКШ, ЦДАШ	1.614	94
ХАРИЛЦАА ХОЛБОО	(100мм)4+0, 2+0, 1+0	0.51	46

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ:

ДУЛААН ХАНГАМЖ: ~~2ф800/500/400/350/300/250/200/150мм~~ **ийн голчтой 0.177 км дулааны шугам төлөвлөж буй тусгай замын нийтийн тээвэрийн трасст (BRT) өртсөн дулааны шугам сүлжээний суваг, сувгийн хучилтыг хүчитгэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулах.**

д/д	Шугамын төрөл	Шугамын нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тесевт ертег (мсн.тг)	Тайлбар
1	Дулаан хангамж	УБДС магистраль шугам	2ф400/500мм	км	0.441	7,213.1	2.4х3.0м(h) хэмжээтэй 441у/м нэвтрэх сувагт 5ж,7г,6д магистраль 2ф400/500мм голчтой шугам угсрах-Зорчих хэсэг, зогсоолд ертсен шугам сүлжээг зөвж шилжүүлэх, нэвтрэх сувагт угсрахаар төлөвлөлтийн шийдэл боловсруулсан. Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
2		ОСНААУГ-ын эзэмшлийн шугам	2ф80/200/300 мм	км	0.196	2,747.5	2.4х3.0м(h) хэмжээтэй 196 у/м нэвтрэх сувагт ОСНААУГ-ын эзэмшлийн 2ф300/200/80мм голчтой дулааны шугам угсрах-Зорчих хэсэг, зогсоолд ертсен шугам сүлжээг зөвж шилжүүлэх, нэвтрэх сувагт угсрахаар төлөвлөлтийн шийдэл боловсруулсан. Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
3	Ус хангамж, ариутгах татуурга	Ус хангамж	2ф200/400мм	км	2.606	2.560.6	Зорчих хэсэг, зогсоолд ертсен шугам сүлжээг зөвж шилжүүлэх, нэвтрэх сувагт угсрахаар төлөвлөлтийн шийдэл боловсруулсан. Дулааны шугамын төлөвлөлттэй уялдуулан нэвтрэх сувагт төлөвлөсөн. Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
4		Ариутгах татуурга	2ф300/500мм	км	0.874	0.813	Зорчих хэсэг, зогсоолд ертсен шугам сүлжээг зөвж шилжүүлэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулсан. Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
5	Инженерийн бэлтгэл арга хэмжээ	Борооны усны шугам	2ф200/1000мм	км	18.58	13,660.4	462 у/м газар лотки шинээр угсрах, замын борооны ус зайлуулах төмөр бетон, хуванцар ф200/1000мм голтой 18.6км хоолойг зөвж шилжүүлэх шинээр угсрахаар төлөвлөлтийн шийдэл боловсруулсан. Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
6	Мэдээлэл холбооны сүлжээ	Мэдээлэл холбооны сүлжээ	4+0,12+0, ф110мм	км	2.66	7,397.7	Зорчих хэсэг, зогсоолд ертсен шугам сүлжээг зөвж шилжүүлэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулсан.Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
7	Цахилгаан хангамж	ЦДКШ	10кВ-ын ЦДКШ	км	7.75	2,833.45	Зорчих хэсэг, зогсоолд ертсен шугам сүлжээг зөвж шилжүүлэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулсан.Зам талбайн нөхөн сэргээлтийн зардал тесевт ертегт тусгагдаагүй.
	ДҮН				33.11	36,413.6	

Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/1402 тоот захирамжийн хүрээнд

“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гаргасан “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадахыг онооны аргаар үнэлэх” аргачлалын дагуу нийслэлийн гамшгийг тэсвэрлэх чадахын үнэлгээг хийж, эрсдэлийг тодорхойлж, зөвлөмж боловсруулан эрсдэлийг бууруулах ажлын хэсэгт томилогдон 2025 оны 10 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд Нийслэлийн Онцгой байдлын газрын байранд ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 03 өдөр Дугаар А/1402 Улаанбаатар хот

Гамшгийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам” 190 дүгээр тогтоолын 3.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 4.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/113 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор нөхцөл байдлын мэдээг цуглуулах, болзошгүй эрсдэлийг тодорхойлж, зөвлөмж гаргах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлгээ хийх ажлын хөтөлберийг 3 дугаар, шаардагдах зардлын тооцоог 4 дүгээр хавсралтаар тус тус батлагдугай.

2.Нэгдсэн Үндэстний байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гаргасан “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалын дагуу 2025 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (П.Хадбаатар)-т даалгасугай.

3.Гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэхэд шаардлагатай 817,000 (найман зуун арван долоон мянга) төгрөгийн зардлыг Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т, төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг тус газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан хуваарилж, тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар (Г.Галбадрах)-т тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1725026303

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/1402 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ ОНООНЫ АРГААР ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гаргасан “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалын дагуу нийслэлийн гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээг хийж, эрсдэлийг тодорхойлж, зөвлөмж боловсруулан эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр.Үйл ажиллагаа

2.1.Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, гамшгийн нөхцөл байдлын мэдээг цуглуулах;

2.2.Ажлын хэсэг гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг боловсруулах, эрсдэлийг тодорхойлох, зөвлөмж гаргах;

2.3.Ажлын хэсгийн гишүүд үнэлгээний аргачлалын дагуу холбогдох судалгаа, танилцуулга бэлдэж ирэх;

2.4.Дүүргийн ажлын хэсгийн бүрэлдэхүүний үйл ажиллагаанд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хяналт тавих.

Гурав.Үнэлгээний зохион байгуулалт

3.1.Танхим, цахим хэлбэрээр зохион байгуулагдана. Нийслэлийн Онцгой байдлын газраас арга зүйгээр хангаж, цахимаар холбогдож, нийслэл, дүүргийн үнэлгээний ажлын хэсэг танхимын хэлбэрээр ажиллана.

3.2.Нийслэлийн хэмжээнд оролцогчид тус санаачилгын хөрөнгөтөөр үе шат бүхий “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот 2030” болон “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалын тухай мэдээлэл олгох нэгдсэн сургалтад хамрагдана.

3.3.Оролцогчид 9 дүүрэг тус бүрээр бүлэгт хуваагдан “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалын дагуу 10 үндсэн чиглэлийн хүрээнд үнэлгээ хийнэ.

3.4.Үндсэн 10 чиглэлийн дагуу үнэлгээг хийж гүйцэтгэсний дараа оролцогчид үр дүнг танилцуулан хэлэлцүүлж, тайлан боловсруулна.

Дөрөв.Хугацаа

4.1.Нийслэлийн Онцгой байдлын газрын сургалтын танхимд 2025 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд болно.

Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 133 дугаар Тогтоолын дагуу Нийслэлийн дулааны эрчим хүчний чадлын дутмагшил, агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор “Тархмал дулааны эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд сайжруулсан шахмал түлшнээс шатдаг хийн түлшинд шилжүүлэх ажлын хүрээнд

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороонд баригдах шингэрүүлсэн байгалийн хий хүлээн авах, хадгалах, дахин хийн төлөвт хувиргах байгууламж, хий дамжуулах, түгээх сүлжээний техник эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл боловсруулах даалгаварыг хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 54 дүгээр хэлэлцүүлж МЗХ 2025-54-001 дугаартай даалгавар батлуулан Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК хүлээлгэн өгсөн. Дарь-Эх орчмын айл өрх, аж ахуйн нэгжүүдийг хатуу түлшнээс байгалийн хийн түлшинд шилжүүлэх, Дэнжийн 1000 93 МВт Дулааны хийн станцад байгалын шингэрүүлсэн хийгээр хангах.

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
ЧТӨГСДЭЛГЭР

УЛААНБААТАР ХОТ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 24-Р ХОРООНД БАРИГДАХ ШИНГЭРҮҮЛСЭН БАЙГАЛИЙН ХИЙ ХҮЛЭЭН АВАХ, ХАДГАЛАХ, ДАХИН ХИЙН ТӨЛӨВТ ХУВИРГАХ БАЙГУУЛАМЖ, ХИЙ ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СУЛЖЭЭНИЙ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 11-р сарын 18 Дугаар МЗХ 2025/54-001 Улаанбаатар хот

1.	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их хурлын 2020 оны 5 сарын 13-ний өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа- 2050" монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг; - Монгол улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолоор хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний Дарь-Эх нэгж хороолол - Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 3 сарын 19 өдрийн "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 133 дугаар тогтоол, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхийн халаалтыг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшинд шилжүүлэх; гэр, амины орон сууцны дулаалгыг дэмжих, хатуу түлшний хэрэглээнд хяналт тавих; - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд (А/651) болон Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын Захирагч (А/963)-ийн 2025 оны 07-р сарын 22-ны өдрийн хамтарсан "Агаарын чанарыг сайжруулах бүс"-ийг шинэчлэн тогтоох, тухайн бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлагдсан эрх зүйн акт; - Нийслэлийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/974 дугаар захирамж; - Хот байгуулалтын асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 54 дугаар хурлын шийдвэр;
2.	Байршил	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо Цагаан даваа орчны байрлах шингэрүүлсэн байгалийн хийн байгууламжийн 50000м2 газар
3.	Зориулалт, хүчин чадал	Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Дарь-Эх орчмын айл өрх, аж ахуйн нэгжүүдийг хатуу түлшнээс байгалийн хийн түлшинд шилжүүлэх, агаарын бохирдлыг бууруулах. - Шингэрүүлсэн байгалийн хий хадгалах савны нийт багтаамж 1500-2000 м³, - Шугам хоолойг эхний шатанд 10000 м³/цаг хий дамжуулах хүчин чадал шаардлагатай, ирээдүйд 30000 м³/цаг хий дамжуулах хүчин чадлын боломжтой байхаар төлөвлөх;
4.	Технологийн үндэсн шаардлага	- ШиБХ хадгалах криоген резервуар сав, хуршуулагч систем, компрессор насос, бамбарын байгууламж зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүд нь олон улсын стандартын шаардлага хангасан байх. - Шугамын трасс, налуу ба салбаруудыг стандартын дагуу онооцтой төлөвлөж, хаалт-арматурыг ашиглалт/засварт

БАРИЛГАЖИХ ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(Дугаар: 2025/54-001-Архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Баянзүрх дүүргийн 21,24-р хороо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Хийн хангамж



Масштаб 1:25000 Түсвэр: EPSG:32648 (Ажлын зураг төсөл боловсруулах бүсэлгэврын хамрах хүрээнд.)

ТАНИХ ТЭМДЭГ

Төлөвлөх бүй барилгажих талбай

Хийн түлшинд шилжих 7000 айл өрхийн төлөвлөлтийн хил

Төлөвлөх бүй хий дамжуулах гол шугам трасс

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөх бүй ӨЗМВт хийн дулаан станц
2	Төлөвлөх бүй хий дамжуулах гол шугам
3	Төлөвлөх бүй хий дамжуулах түгээх станц
4	Төлөвлөх бүй хий хадгалах, дахин хийн төлөвт хувиргах байгууламж
5	Хийн түлшинд шилжих 7000 айл өрхийн төлөвлөлтийн хил

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс

Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын зам 17100/, Нэгдэмдэнгийн зам 1200
Цахим хуудас: www.ubfa.ub.gov.mn, www.eberiga.ub.gov.mn
Утас: 72707700

Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, 2020 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 189 дүгээр тогтоол

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн дэд бүтцийн удирдах газар ОНӨААТҮГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 26,31,107,49,72 дугаар халаалтын зуухнуудын дэвшилтэт технологиор шинэчлэх ажлын зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулан Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцүүлэх мэргэжлийн зөвлөлийн 57 дугаар хэлэлцүүлж МЗХ 2025-57-002,003,004, МЗХ 2025-60-001,002 дугаартай даалгаварууд батлуулан Ану сервис ХХК-д хүлээлгэн өгсөн.

"ХЭСЭГЧИЛСЭН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН УДИРДАХ ГАЗАР" ОНӨААТҮГ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАРТ

Хүсэлт гаргах тухай

"Ану сервис" ХХК нь 2004 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн "Халаалтын зуухны ашиглалт, эзэмшүүлэлтэн газар НӨҮГ-ын харьяа халаалтын зарим зуухыг хэрэгцэ оруулалтын зарчмаар менежментийн гэрээгээр ажиллуулах гэрээ"-ээр нийслэлийн Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороонд байрлах 107 дугаар халаалтын зуухны үйл ажиллагааг хариуцан ажиллаж.

Монгол улсын Ерөнхий сайд, Засгийн газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр", Засгийн газрын "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус компани нь өөрийн хариуцаж байгаа усан халаалтын зуухнуудыг хийн зуухаар солих технологи шинэчлэгийн ажлыг хийж байна.

Иймд тус технологи шинэчлэлтийн ажилд ажлын даалгавар гаргаж өгч туслалцаа үзүүлнэ үү.

Хэсэгчилсэн Инженерийн Хангамжийн Удирдах Газар
Хүлээлгэж
Газрын дарга
Цэвээн Ганбаатар
2025.11.07 16:22

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 72 ДУГААР СУРГУУЛЬ

Хүсэлт гаргах нь

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороонд байрлах 72 дугаар сургуулийн халаалтын зуухны үйл ажиллагааг хариуцан ажилладаг Ану Сервис ХХК нь Монгол Улсын Агаарын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа усан халаалтын зуухнуудыг хийн зуухаар солих технологи шинэчлэлийн ажлыг хийж байна.

Иймд тус технологийн шинэчлэлтийн ажилд ажлын даалгавар гарган өгч туслалцаа үзүүлнэ үү.

Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургууль
Удирдлага
Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Пүрэвсүрэн Өлзийхишиг
2025.11.12 16:53

Халаалтын 26 дугаар зуух

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ч.ТӨГСДЭЛГЭР

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРООНД БАЙРЛАХ 26 ДУГААР ХАЛААЛТЫН ЗУУХЫГ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИОР ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 12-р сарын 02 Дугаар МЗХ 2025/57-002 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг; - Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, 2020 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 189 дүгээр тогтоол; - Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай" 123 дугаар тушаал; - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгдийн хурлын 2018 оны "Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө батлах тухай" 17/10 дугаар тогтоол; - Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" А/1377 дугаар захирамж; - Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/1228 дугаар захирамж; - Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Хийн халаалтад шилжүүлэх тухай" А/63 дугаар тушаал; - Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 2025 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 317 дугаартай албан бичиг; - 2025 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 57 дугаар хурлын шийдвэр;
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	**I үе шаттай** - Халаалтын зуухыг дэвшилтэт технологиор шинэчлэх ижбүрэн ажлын зураг төсөл боловсруулах **Хугацаа** Гэрээнд заасан хугацаанд
3.	Байршил, газар эзэлбэрийн одоогийн байдал	- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ эзэлбэр газарт байрлах халаалтын зуух.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулинуд:** - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар эмчлүүлэх тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль;

ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ
(Дугаар: 2025/57-002 Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Чингэлтэй дүүргийн 13-р хороо	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ	Хийн халаалт



Масштаб 1:500 Түсвэр: EPSG:32648 (Ажлын зураг гаргах боловсруулах даалгаврын хавсралт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

10м³ хийн далд сав

17-р сургууль

Одоо байгаа халаалтын зуух

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй 10м³ далд сав
2	Одоо байгаа уурын зуух
3	Ерөнхий боловсролын 17 дугаар сургууль
4	Хэлбэмбагийн талбай
5	56 дугаар цэцэрлэг

Халаалтын 31 дугаар зуух

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ч.ТӨГСДЭЛГЭР

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 2 ДУГААР ХОРООНД БАЙРЛАХ 31 ДҮГЭЭР ХАЛААЛТЫН ЗУУХЫГ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИОР ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 12-р сарын 02 Дугаар МЗХ 2025/57-003 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг; - Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, 2020 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 189 дүгээр тогтоол; - Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай" 123 дугаар т ушаал; - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгдийн хурлын 2018 оны "Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө батлах тухай" 17/10 дугаар тогтоол; - Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" А/1377 дугаар захирамж; - Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/1228 дугаар захирамж; - Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Хийн халаалтад шилжүүлэх тухай" А/63 дугаар тушаал; - Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 2025 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 318 дугаартай албан бичиг; - 2025 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 57 дугаар хурлын шийдвэр;
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	**I үе шаттай** - Халаалтын зуухыг дэвшилтэт технологиор шинэчлэх ижбүрэн ажлын зураг төсөл боловсруулах **Хугацаа** Гэрээнд заасан хугацаанд
3.	Байршил, газар эзэлбэрийн одоогийн байдал	- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ эзэлбэр газарт байрлах халаалтын зуух.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулинуд:** - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар эмчлүүлэх тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль.

ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ
(Дугаар: 2025/57-003 Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Сонгинохайрхан дүүргийн 2-р хороо	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ	Хийн халаалт



Масштаб 1:500 Түсвэр: EPSG:32648 (Ажлын зураг гаргах боловсруулах даалгаврын хавсралт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

200кг 8ш хийн сав

42-р сургууль

Одоо байгаа халаалтын зуух

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй 200кг 8ш хийн сав
2	Одоо байгаа уурын зуух
3	Сургуулийн өргөтгөлийн барилга
4	Хэлбэмбагийн талбай
5	Ерөнхий боловсролын 42 дугаар сургууль

Халаалтын 107 дугаар зуух

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ч.ТӨГСДЭЛГЭР

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР ХОРООНД БАЙРЛАХ 107 ДУГААР ХАЛААЛТЫН ЗУУХЫГ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИОР ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 12-р сарын 02 Дугаар МЗХ 2025/57-004 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг; - Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, 2020 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 189 дүгээр тогтоол; - Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай" 123 дугаар тушаал; - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны "Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө батлах тухай" 17/10 дугаар тогтоол; - Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" А/1377 дугаар захирамж; - Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/1228 дугаар захирамж; - Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Хийн халаалтад шилжүүлэх тухай" А/63 дугаар тушаал; - Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 2025 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 316 дугаартай албан бичиг; - 2025 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 57 дугаар хурлын шийдвэр;
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	**I үе шаттай** - Халаалтын зуухыг дэвшилтэт технологиор шинэчлэх иж бүрэн ажлын зураг төсөл боловсруулах **Хугацаа** Гэрээнд заасан хугацаанд
3.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ эдэлбэр газарт байрлах халаалтын зуух.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд:** - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль;

ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ
(Дугаар 2025/57-004 Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зорилалт
Хан-Уул дүүргийн 9-р хороо	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ	Хийн хангамж



Масштаб 1:500 Тусгаа: EPSG:32648 (Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын хамт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

200кг бш хийн сав

Одоо байгаа халаалтын зуух

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй 200кг бш хийн сав
2	Одоо байгаа уурын зуух

Халаалтын 49 дугаар зуух

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ч.ТӨГСДЭЛГЭР

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРООНД БАЙРЛАХ 49 ДҮГЭЭР ХАЛААЛТЫН ЗУУХЫГ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИОР ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 12-р сарын 02 Дугаар МЗХ 2025/60-002 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг; - Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, 2020 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 189 дүгээр тогтоол; - Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай" 123 дугаар тушаал; - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны "Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө батлах тухай" 17/10 дугаар тогтоол; - Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" А/1377 дугаар захирамж; - Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/1228 дугаар захирамж; - Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Хийн халаалтад шилжүүлэх тухай" А/63 дугаар тушаал; - Нийслэлийн ерөнхий боловсролын 49 дүгээр сургуулийн 2025 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн 38 дугаартай албан бичиг; - 2025 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 60 дугаар хурлын шийдвэр;
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	**I үе шаттай** - Халаалтын зуухыг дэвшилтэт технологиор шинэчлэх иж бүрэн ажлын зураг төсөл боловсруулах **Хугацаа** Гэрээнд заасан хугацаанд
3.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	- Нийслэлийн ерөнхий боловсролын 49 дүгээр сургуулийн эдэлбэр газарт байрлах халаалтын зуух.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд:** - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль;

ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ
(Дугаар: 2025/60-002 Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зорилалт
Чингэлтэй дүүргийн 13-р хороо	Нийслэлийн ерөнхий боловсролын 49 дугаар сургууль	Хийн хангамж



Масштаб 1:500 Тусгаа: EPSG:32648 (Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын хамт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

10м³ хийн далд сав

Одоо байгаа халаалтын зуух

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй 10м³ далд сав
2	Одоо байгаа уурын зуух
3	Ерөнхий боловсролын 49 дугаар сургууль
4	Спорт заал
5	83 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР Э.УЯНГА-ИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Хот байгуулалт, хотын стандартын газар

Нэгжийн нэр: Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1	2	3	4	5	6
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
ЗОРИЛГО 1. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:					
Зорилт 1.1. Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км урт Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-1)*					
1	Арга хэмжээ 1.1.1. Метро төслийн трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	60	10	70	
ЗОРИЛГО 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
УЛААНБААТАР "20 МИНУТЫН ХОТ"					
Зорилт 1.2. Буянт-Ухаа спорт цогцолбороос 120 мянгатын уулзвар, Сүхбаатарын талбай хүртэл 13.1 км урттай болон Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруу Намъянжүгийн гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урттай “Тусгай замын автобус” /BRT/ төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-2)*					
2	Арга хэмжээ 1.2.1. Тусгай замын автобусны трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	60	10	70	
Зорилт 1.3. Зунжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай хүртэл 20.4 км урт “Улаанбаатар хөнгөн галт тэрэг” төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(НЗДҮАХ-3)*					
3	Арга хэмжээ 1.3.1. Хөнгөн галт тэрэг төслийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	60	10	70	
Зорилт 1.4. Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Агаарын дүүжин замын тээвэр” Төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-4)*					
4	Арга хэмжээ 1.4.2. Төслийн 1-р шугам буюу "Яармаг, Арцат-Өнөр хороолол" шугамын ажилд санал өгч, зөвшилцөх	60	10	70	
Зорилт 2.2. Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж батлуулна. (*ЗГҮАХ - 1.1.1.1, НХТЖҮЧ- 9.1, НЗДҮАХ-ийн – 1.1.2)*					
5	Арга хэмжээ 2.2.1. “Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний дулаан хангамжийн төлөвлөлтийн шийдэлд санал зөвлөмж	60	10	70	

1	2	3	4	5	6
	хүргүүлэх, зөвшилцөх, төлөвлөлтийн шийдлийг холбогдох байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах Улсын Их Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг ханган ажиллах.				
6	Арга хэмжээ 2.2.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дулаан хангамжийн төлөвлөлтийг ХТСИ-тэй зөвшилцөн хяналт тавьж ажиллах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	60	10	70	
Зорилт 2.3. “Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг, салбаруудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. *(ЗГҮАХ -1.1.1.1, НЗДҮАХ-ийн – 1.2.3)*					
7	Арга хэмжээ 2.3.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, дулаан хангамжийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлэх, зөвшилцөх хяналт тавьж ажиллах. (14 хот)	60	10	70	
8	Арга хэмжээ 2.3.3. Агросити дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, дулаан хангамжийн төлөвлөлтийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлэх, зөвшилцөх, хяналт тавьж ажиллах.	60	10	70	
9	Арга хэмжээ 2.3.4. Шаргаморьт дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, дулаан хангамжийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлэх, зөвшилцөх, хяналт тавьж ажиллах.	60	10	70	
Зорилт 1.4. Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Агаарын дүүжин замын тээвэр” Төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-4)*					
10	1.4.2. Төслийн 1-р шугам буюу "Яармаг, Арцат-Өнөр хороолол" шугамын ажилд санал өгч, зөвшилцөх	60	10	60	
ОЛОН ТӨВТ ХОТ					
Зорилт 2.4. Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна. Нийслэл Улаанбаатар хотод шинээр байгуулах орон нутгийн зэрэглэлтэй Хан-уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 42 хорооллыг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, “Нэг төвт хотоос олон төвт хот”-ын тогтолцоог бүрдүүлнэ. *(НЗДҮАХ-ийн – 1.2.1)*					
11	Арга хэмжээ 2.4.1. Сэлбэ дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтийн төслийн дэд бүтэц, дулаан	60	10	70	

1	2	3	4	5	6
	хангамжийн шугам сүлжээний ажлын даалгавар боловсруулах, төлөвлөлтийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлэх, төлөвлөлтийн шийдэл, ажлын зураг төсөл зөвшилцөх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.				
12	Арга хэмжээ 2.4.2. Толгойт, Сэлбэ дэд төв орчмын II ээлж, Дамбадаржаа дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн дэд бүтэц, дулаан хангамжийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөх, ажлын даалгавар боловсруулах, газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх.	60	10	70	
13	Арга хэмжээ 2.4.3. Дарь-Эх, Монель, Тахилт олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн дэд бүтэц, дулаан хангамжийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөх, ажлын даалгавар боловсруулах, газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх.	60	10	70	
АВТО ЗАМ					
Зорилт 2.28. “Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламж барих” төслийг хэрэгжүүлнэ. *(ЗГҮАХ-1.1.5.2, НЗДҮАХ-ийн – 1.4)*					
14	Арга хэмжээ 2.28.1. Эрчим хүчний гудамжнаас Энхтайваны өргөн чөлөө дээгүүр шинээр гүүрэн байгууламжийн ажлын зураг төсөл зөвшилцөх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах.	60	10	70	
15	Арга хэмжээ 2.28.2. Хан-Уул дүүрэг 4, 23-р хороо Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох авто замын Наадамчдын гудамжны авто зам дээгүүр шинээр гүүрэн байгууламжийн ажлын зураг төсөл зөвшилцөх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах.	60	10	70	
ЗОРИЛГО 3. ХУУЛИАР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:					
Зорилт 3.1. Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:					
16	Арга хэмжээ 3.1.1. Газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах.	53.94	10	63.94	
17	Арга хэмжээ 3.1.2. Газарт нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон Улсын стандартын сайжруулалтыг хийх.	53.94	10	63.94	

1	2	3	4	5	6
18	Арга хэмжээ 3.1.4. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 захирамж “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд тодорхой ажил санаачлан төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлэх.	60	10	70	
Зорилт 3.2. Барилга, хот байгуулалтын үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:					
19	Арга хэмжээ 3.2.7. Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар батлах	60	2	62	
Зорилт 3.7. Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хүрээнд:					
20	Арга хэмжээ 3.7.1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төслийг хянах, зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавих.	47.88	5	57.9	
Зорилт 3.10. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:					
21	Арга хэмжээ 3.10.2. Хууль, шүүхийн байгууллагад Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ерөнхий архитектор болон Газрын даргын шийдвэртэй холбоотой эрх зүйн маргаанд нэгжийн чиг үүргийн хүрээнд итгэмжлэлээр оролцох.	60	10	70	
22	Арга хэмжээ 3.10.3. Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах.	60	10	70	
23	Арга хэмжээ 3.10.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байж, цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх.	60	10	70	
24	Арга хэмжээ 3.10.5. Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах.	60	10	70	
25	Арга хэмжээ 3.10.14. Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулах	53.9	10	63.9	

1	2	3	4	5	6
26	Арга хэмжээ 3.10.18. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (2024-2030) 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	60	10	70	
27	Арга хэмжээ 3.10.25. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлыг зохион байгуулах.	60	10	70	
28	Арга хэмжээ 3.10.29. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, егр системийн ашиглалтыг сайжруулж зөрчилгүй ажиллах.	60	10	70	
ЗОРИЛГО 4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
Зорилт 4.1. Газраас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.					
32	Арга хэмжээ 4.1.1. Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, дулаан хангамжийн мэдээллийг ил тод байдлыг хангах.	60	10	70	

1. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1 Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/853 дугаар захирамж Зогсоол хөтөлбөрийн хүрээнд	60	10	70	
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2 Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/652 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг	60	10	70	
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/20 дугаартай газрын даргын тушаал 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/48 дугаартай газрын даргын тушаал	60	10	70	
	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4 БОУАӨЯ, ГЗБГЗЕГ-ын хамтарсан тушаалаар батлагдсан А/181, А/193 батлагдсан ажлын хэсэг	60	10	70	
	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5 Барилга хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдын тушаал	60	10	70	
	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6 Нийслэлийн шуурхай штабаас өгсөн үүрэг даалгавар	60	10	70	
Дундаж оноо				64.9	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4

1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдана.	100	13.5	13.5
Дундаж оноо			13.5	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7.00	
2.	Дүн шинжилгээ хийх	6.33	
3.	Асуудал шийдвэрлэх	6.00	
4.	Хариуцлагатай байдал	7.00	
5.	Ажлын цаг ашиглалт	7.00	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	6	
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	5	
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	6	
Дундаж оноо		6.29	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7.63
2.	Багаар ажиллах	7.36
3.	Харилцаа	7.53
Дундаж оноо		7.51

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)*	*64.90*
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	*13.0*
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)*	*6.3*
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)*	*7.51*
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)*	*(..... оноо)*
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.20

Үнэлгээ өгсөн: *Нэгжийн дарга*

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН
ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА ..... (Ц.ЛХАМСҮРЭН)

(албан тушаал) *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

9024050025
2117401 СБТ24872

2025.12.05 *(огноо)*

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

..... *(гарын үсэг)* (Э.УЯНГА) *(албан хаагчийн нэр)*

2025.12.15 *(огноо)*

Үнэлгээг хянасан:
Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)

..... *(гарын үсэг)* (Д.ДАШЦЭЦЭГ) *(албан хаагчийн нэр)*

2025.12.15 *(огноо)*

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал)

..... *(гарын үсэг)* (Т.БУЯНЖАРГАЛ) *(албан хаагчийн нэр)*

2025.12.15 *(огноо)*

Үнэлгээг баталгаажуулсан:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

..... *(гарын үсэг)* (Г.БАЯРСАЙХАН) *(албан хаагчийн нэр)*

2025.12.15 *(огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР Э.УЯНГА-ын 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

д/д	*Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж*	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн Дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛГО 1. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД							
Зорилт 1.1. Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км урт Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. (ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-1)							
1.	1.1.1. Метро төслийн трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	50	50	Метро төслийн трасс дагуу төлөвлөсөн 15 буудлын ус хангамж, ариутгах татуургын хэсгийн давхцалыг мэдээллийн сантай тулган төслийн багт тухай бүр тодруулга өгч ажилласан. УСУГ-аас ирүүлсэн нэмэлт тодруулгыг нэгтгэсэн.	100	100
	Зорилт 1.2. Буянт-Ухаа спорт цогцолбороос 120 мянгатын уулзвар, Сүхбаатарын талбай хүртэл 13.1 км урттай болон Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруу Намъянжүгийн гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урттай "Тусгай замын автобус" /BRT/ төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-2)*						
	1.2.1. Тусгай замын автобусны трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50	50	Нийслэлийн Засаг даргын А/652 захирамжийн хүрээнд "Нийслэл Улаанбаатар хотын тусгай замын автобус" BRT төслийн трассын дагуух инженерийн шугам сүлжээний тодруулга болон зогсоолын хэсэгт давхцаж буй зөөж шилжүүлэх инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог	100	100

	1	2	3	4	5	6	7
					боловсруулан хангагч байгууллагууд-тай зөвшилцөж танилцуулах материал бэлтгэн Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ийн Автобусны тусгай замын төслийн нэгжид хүргүүлсэн.		
	Зорилт 1.3. Зунжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай хүртэл 20.4 км урт “Улаанбаатар хөнгөн галт тэрэг” төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. (НЗДҮАХ-3)						
	1.3.1. Хөнгөн галт тэрэг төслийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50	50	“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-аас ирүүлсэн архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах тухай хүсэлтийн дагуу Монгол Улсын сайд 20 минутын хот Үндэсний хорооны даргын А/10 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370, А/1553 дугаар “Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх төсөл”-ийн Техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг, төсөв боловсруулах, захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.	100	100
	Зорилт 1.4. Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Агаарын дүүжин замын тээвэр” Төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. *(ЗГҮАХ- 1.1.5.3, НЗДҮАХ-4)*						
	1.4.2. Төслийн 1-р шугам буюу "Яармаг, Арцат-Өнөр хороолол" шугамын ажилд санал өгч, зөвшилцөх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50	50	2023 оны 04 сарын 17-ний өдрийн МЗХ2023/09-013 дугаартай даалгаврыг Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Яармаг талын зогсоолд өөрчлөлт оруулан 2025.02.14-ний өдрийн 2025/00-164 Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлуулсан. Тайлант хугацаанд нэмэлт санал оруулаагүй байна.	100	100
	ЗОРИЛГО 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
	УЛААНБААТАР "20 МИНУТЫН ХОТ"						

	1	2	3	4	5	6	7
	Зорилт 2.2. Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулна. *(ЗГҮАХ -1.1.1.1, НХТЖҮЧ- 9.1, НЗДҮАХ-ийн – 1.1.2)*						
	2.2.1. "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Улсын Их Хуралд өргөн барьж, батлуулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50	50	Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэлд санал өгч ажилласан байна. Тайлант хугацаанд тухайн хэсэгт нэмэлт санал оруулаагүй байна.	100	100
	2.2.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХТСИ-тэй зөвшилцөн хяналт тавьж ажиллах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50	50	Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэлд санал өгч ажилласан байна. Тайлант хугацаанд тухайн хэсэгт нэмэлт санал оруулаагүй байна.	100	100
	Зорилт 2.3. "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг, салбаруудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. (ЗГҮАХ -1.1.1.1, НЗДҮАХ-ийн – 1.2.3)						
	2.3.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, авто замын сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөн хяналт тавьж ажиллах. (14 хот)	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50	50	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн даалгаварт санал өгсөн, шугам сүлжээний одоогийн байдалд үнэлгээ хийж ажилласан. Нийслэлийн Засаг даргын захирамжийн А/548 дугаар захирамжийн хүрээнд 14 хотын инженерийн шугам сүлжээний хүртээмжийн одоогийн байдлын судалгааг гарган, шугам сүлжээний хүртээмжийн үнэлгээг ус хангамж, ариутгах татуургын системийн хүрээнд хийж, нэгтгэсэн. 42 нэгж хороолол, VII дугаар нэгж хорооллын инженерийн шугам сүлжээний одоогийн байдлын	100	100

	1	2	3	4	5	6	7
					үнэлгээний нэгтгэл хийж, танилцуулга (ppt) бэлтгэсэн.		
36	Арга хэмжээ 3.10.18. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (2024 -2030) 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	50	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэн, өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод байдлыг хангуулан иргэдээс ирсэн өргөдөл гомдолд шуурхай хариу өгч ажилласан. Авлагатай тэмцэх газраас 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт бөглөх шинэчлэлтийн талаарх сургалтад хамрагдсан.	01-12	100
37	Арга хэмжээ 3.10.24. Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	50	Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газараас зарласан сургалтад тухай бүр хамрагдаж байна.	01-12	100
38	Арга хэмжээ 3.10.25. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	50	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний бүрээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Айцын аманд 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр	01-12	50

	1	2	3	4	5	6	7
					тарьж, суулгасан модны арчилгаа, нөхөн тарилтын ажлыг хийж гүйцэтгэв.		
39	Арга хэмжээ 3.10.29. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, erp системийн ашиглалтыг сайжруулж зөрчилгүй ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	50	Тайлангийн хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг судлан шуурхай хариу өгч, зөрчил гаргалгүй ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног, 23 цаг, 31 минут байна. Ирсэн өргөдөл – 6. ➢ Судалж байгаа – 0 ➢ Шийдвэрлэсэн – 6 Шийдвэрлэлтийн дундаж хугацаа – 4 хоног 18 цаг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ирсэн бичиг шийдвэрлэлт. Ирсэн бичиг – 68. ➢ Судалж байгаа – 0 ➢ Шийдвэрлэсэн – 68 Шийдвэрлэлтийн дундаж хугацаа – 6 хоног	01-12	100
40	Арга хэмжээ 3.10.30. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	50	2024 үүссэн Архивын бичиг баримт, үүссэн нэгжийг хүлээлгэн өгсөн. Үүнд: Инженерийн дэд бүтэц төлөвлөх даалгавар олгох болон Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар олгоход үүсэн 2 боть баримтыг Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн.	01-12	100
ЗОРИЛГО 4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
Зорилт 4.1. Газраас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.							
41	Арга хэмжээ 4.1.1. Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	50	“Хэрэглэгчийн үнэлгээ хийх судалгааны баг байгуулах тухай” Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр авах арга	01-12	100

	1	2	3	4	5	6	7
					хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 17-27-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Google forms” программыг ашиглан судалгааг авсан ба хялбар, хурдан хариулах боломжтой 9 асуулгатай байсан бөгөөд мэдээллийг уншуулах код, зааварчилгааг Угтах үйлчилгээний цэг болон хэлтсүүдийн үүдэнд ил байршуулан судалгааг авч ажилласан.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
42	Газрын даргын 2025 оны Б/49 дүгээр тушаалаар Замын хөдөлгөөн, төлөвлөлт хариуцсан инженерийн албан үүргийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд түр орлон гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Замын хөдөлгөөн, төлөвлөлт хариуцсан инженерийн албан үүргийг гүйцэтгэх хугацаанд авто зам, замын байгууламж төлөвлөх 22 даалгавар батлагдсан ба хот байгуулалтын судалгаа хийн, мэдээллийн санд трассын мэдээлэл оруулж ажилласан. Мөн ажил орлон хариуцан үед авто замтай холбоотой 7 бичиг ирснийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан байна.	04-06	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан цаг	-	/дунджаар 30/ цагаас багагүй байх/	- Төрийн албанаас зохион байгуулсан сургалтанд тухай бүр хамрагдсан. - Дэлхийн банк, “Тогтвортой зам тээвэр” төслийн нэгжээс зохион байгуулсан чадавхийг нэмэгдүүлэх “Дугуйн замын төлөвлөлт” сэдэвт 16 цагийн сургалтанд хамрагдсан. - НҮБ-ын ХАБИТИТ, ШУТИС-ын Барилга Архитектурын Сургууль, Монголын	01-12	100

1	2	3	4	5	6	7	8
					барилгын инженерүүдийн холбоо, БНХАУ-ын процессор, инженерүүдийг урьж зохион байгуулсан “Үерийн хамгаалалтын ногоон дэд бүтэц, тогтвортой ус зайлуулах систем” сэдэвт 18 цагийн сургалтанд 2025 оны 11-р сарын 1-ний өдрөөс 11-р сарын 04-ны өдрүүдэд хамрагдсан.		

Төлөвлөгөө тайлагнасан:

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН ..... /О.БАТТУЛГА/
(албан тушаал) *(гарын үсэг)* *(нэр)*

2025.12.05
(огноо)

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН

О.БАТТУЛГА

2025 оны ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН



Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн
Газар зохион байгуулалт геодези зураг зүйн асуудал хариуцсан ажилтан О.Баттулга-ын
2025 онд гүйцэтгэсэн

АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 05 өдөр Улаанбаатар хот

НЭГ: ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

МЕТРО ТӨСӨЛ:

2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн 8 дугаар хурлаар Их багтаамжийн нийтийн тээвэр /Метро/ хэлэлцүүлэгдэн дэмжигдэж 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр загвар зураг батлагдсан.

Улаанбаатар метро төсөл нь Толгойтоос Амгалан хүртэл Энхтайвны өргөн чөлөө дагуу 19.4 км урт, 15 өртөө, 1 депо бүхий, цагт 17,200 орчим зорчигч тээвэрлэх хүчин чадалтай төлөвлөгдсөн ба Хот байгуулалтын мэдээллийн санд Метроны шугамын трассыг оруулсан.



Метро төслийн трасс дагуу төлөвлөсөн 15 буудлын инженерийн шугам сүлжээний давхцалыг мэдээллийн сантай тулган төслийн багт тухай бүр тодруулга өгч ажилласан.

“ТУСГАЙ ЗАМЫН АВТОБУС” /BRT/

Нийслэл Улаанбаатар хотод олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл “Нийслэл Улаанбаатар хотын тусгай замын автобус” BRT төслийн төлөвлөлтийг Хот байгуулалтын асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 53 дугаар хурлаар танилцуулсан. Азийн хөгжлийн банкны 74.7 сая USD-ын энгийн зээлийн санхүүжилтээр хэрэгжих Тусгай замын автобус BRT төсөл нь Улсын гуравдугаар төв эмнэлгийн баруун тал Ард аюушийн өргөн чөлөө, Л.Энэбишийн өргөн чөлөө, Их тойруу, Намьяанжүний гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөөг хамарч, трассын урт-12.9км, зогсоол-19ш, нэгдүгээр эгнээний энгийн зогсоол/саравч-5ш, зорчигчийн тоо 25,000-30,000 хүн/өдөр байх ба 2025-2030 онд төслийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.

Нийслэлийн Засаг даргын А/652 захирамжийн хүрээнд Тусгай замын автобус” /BRT/ төслийн трассын дагуух инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хангагч байгууллагуудтай зөвшилцөн ажиллаж байна. Тусгай замын трасст өртсөн инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог хангагч байгууллагуудтай зөвшилцөж ажилласан.



УЛААНБААТАР ХӨНГӨН ГАЛТ ТЭРЭГ:

Зунжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай хүртэл 20.4 км урт “Улаанбаатар хөнгөн галт тэрэг” төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ:

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-аас ирүүлсэн архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах тухай хүсэлтийн дагуу Монгол Улсын сайд 20 минутын хот Үндэсний хорооны даргын А/10 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370, А/1553 дугаар “Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх төсөл”-ийн Техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг, төсөв боловсруулах, “Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай” чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв боловсруулах захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Энэ хүрээнд:



НЭГДҮГЭЭР ШУГАМ:

Зунжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай чиглэл

Шугамын урт: *11 км 15 зогсоолтой*

Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох – 10.8 км урт хойд трассын дагуу газар олголт, хот байгуулалт, төлөвлөлтийн дагуу 2025 оны 02 сарын 27-ны өдрийн МЗХ2025/00-214 дугаартай гол гудамж замын ангиллын Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар гарсан.



ХОЁРДУГААР ШУГАМ:

Сүхбаатарын талбайгаас Буянт-Ухаа цогцолбор чиглэл

Шугамын урт: *15 км 23 зогсоолтой*

Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд – 15.3 км урт урд трассын дагуу газар олголт, хот байгуулалт, төлөвлөлтийн дагуу 2025 оны 02 сарын 28-ны өдрийн 2025/00-219 дугаартай гол гудамж замын ангиллын Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлагдан гарсан.



АГААРЫН ДҮҮЖИН ЗАМЫН ТЭЭВЭР:

Нэгдүгээр шугам: ***- Яармаг, арцат-Өнөр хороолол чиглэлд.***
Шугамын урт: ***- 4.2 км урт, хоёр зогсоолтой, 6.45-42 метр өндөр, нийт 19 тулгуур баганатай***
Оргил цагийн хүчин чадал: ***- 2320 хүн/цаг***
Хэрэгжих хугацаа: ***- 2025 – 2027 он***

2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 2025/00-164 дугаартай Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврыг Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж УТҮГ-ын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/101 дугаартай албан бичгийг үндэслэн ХУД-ийн 23-р хороо, Яармаг “Арцат” буудлаас БГД-ийн 29 хороо, Хархорин худалдааны төвийн автобусны буудал /өнөр хороолол/ хүртэлх агаарын дүүжин замын 2023 оны 04 сарын 17-ний өдрийн МЗХ2023/09-013 дугаартай даалгаврын Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Яармаг талын зогсоолд өөрчлөлт оруулан батлуулсан.







ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭР:



Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Дунд гол, 20-р хорооны нутаг дэвсгэрт, одоогийн байгаа станцаас баруун урд зүгт ойролцоогоор 400м зайд буюу ДЦС-2-ын үнсэн сангийн 20 га талбайд баригдах **"Дулааны 5-р цахилгаан станц"**-ын 300 МВт-ын техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит III-р хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.

Энэ дагуу одоо байгаа үнсэн сангийн хуримтлагдсан үнсийг зөөн шилжүүлэх асуудал үүсэж байгаа ба "Дулааны тавдугаар цахилгаан станц" ОНӨААТҮГ-ын зүгээс зүгээс Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба боон манай газарт хандан тухайн үнсийг Сонгинохайрхан дүүрэг 7, 8-р хорооны нутаг дэвсгэр Ханын материал орчим, тоосгоны үйлдвэрийн шар шаврын орд байгаа газарт зөөн шилжүүлэх боломжтой эсэх талаар хүсэлт ирүүлсэн ба уг хүсэлтийг судлан батлагдсан төлөвлөлт, бүсчлэлийн хувьд тухайн талбайд үнс хадгалах, цуглуулах зориулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулах боломжгүй тухай хариуг хүргүүлэн ажилласан.



"УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААНЫ ХАНГАМЖИЙН ОРГИЛ АЧААЛАЛД АЖИЛЛАХ ДУЛААНЫ ТАРХМАЛ ЭХ ҮҮСВЭР"-ИЙН ГАЗАР ОЛГОЛТЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ.

Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Нийслэлийн дулаан, эрчим хүчний хэрэглээний оргил ачааллын үед ажиллах дулааны тархмал эх үүсвэрийн газар олголтын асуудлыг тусгуулан батлуулсан.

Үүнд: Тархмал эх үүсвэр

- Баянзүрх дүүргийн 26-р хороо, хорооны нутаг дэвсгэрт
  Хийн дулааны эх үүсвэр барих 6.1 га талбай,
- Баянзүрх дүүргийн 26-р хороо, хорооны нутаг дэвсгэрт
  Хийн дулааны эх үүсвэр барих 1.9 га талбай,
- Хан-Уул дүүргийн 8-р хороо, Жаргалантын ам,
  Дулааны эх үүсвэр барих 3.8 га,
- Хан-Уул дүүргийн 11-р хороо, ХААИС-ын Агропаркийн хашаанд

Хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэр барихад 1.8 га, нийт 4 байршлыг төлөвлөгөөнд тусгуулсан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас нийслэлийн Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт одоо барилгажаагүй байгаа хашаалсан газарт Хийн дулааны эх үүсвэрийг байршуулах боломжтой эсэх, газар олголт, Архитектур төлөвлөлтийн даалгавар тухайн байршилд батлагдсан эсэх талаар тодруулга авахаар хүсэлт ирүүлсний дагуу хариуг Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны 02 сарын 25-ны өдрийн 01/233 тоот албан бичгээр хүргүүлсэн



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/15 дугаар захирамжаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IV хуралдааныг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зарлан хуралдуулж Эрчим хүчний яамнаас “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах дулааны тархмал эх үүсвэр”-ийн танилцуулгыг хийсэн. Тус хуралдаанаар төлөвлөж буй тархмал эх үүсвэрийн байршилд байгаль орчны төлөв байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгүүлэх шаардлагатай бөгөөд байгаль орчны үнэлгээг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэр гарсан.

ХОЁР: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

УЛААНБААТАР "20 МИНУТЫН ХОТ"

Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө:



"Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичгийг хэлэлцэх эсэх асуудал 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Монгол Улсын хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэгдэн дэмжигдсэн.

Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний шийдэл боловсруулагдсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж Улсын Их хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдлийг “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨААТҮГ-ны инженерүүдтэй хамтран ажиллаж Улсын их хурлаар оруулах бэлтгэл ажилд хамтран ажилласан.

Инженерийн шугам сүлжээний салбарын бодлого хариуцсан байгууллага Эрчим хүчний яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, БОУАӨЯам, МХХ-ний зохицуулах хороо, Усны бодлогын газар, УБДС ТӨХК, УБЦТС ТӨХК, УСУГ, ГУББГ ОНААТҮГ, Шугам сүлжээний хангагч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний газар зохион байгуулалтын төлөвлөгөөг "Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-д тусгуулах.



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 24/26 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хот байгуулалтын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар санал оруулан ажиллаж байна.

Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажилд Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх хүрээнд

- Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх 10 байршилд
- Цахилгаан хангамжийн барилга байгууламжийн газрыг чөлөөлөх 4 байршилд
- Дулаан хангамжийн барилга байгууламжийн газрыг чөлөөлөх 12 байршилд
- Усан хангамжийн барилга байгууламжийн газрыг чөлөөлөхөд 6 байршилд санал оруулан батлуулан ажилласан.

2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх хүрээнд

- Усан сангийн зориулалтаар 3 байршилд
- Цахилгаан хангамжийн барилга байгууламжийн зориулалтаар 9 байршилд
- Дулааны эх үүсвэрийн 3 байршилд газар олголтыг төлөвлөгөөний тодотголд тусгуулан батлуулах саналыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн ажилласан.

ОЛОН ТӨВТ ХОТ

1. Сэлбэ дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн авто зам, замын байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийн хүрээнд боловсруулагдсан газар олголтын асуудлаар Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Дэд төвүүдийн газрыг чөлөөлөх хүрээнд хийгдэх ажилд Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон дэд бүтцийн барилга, байгууламжийн зориулалтаар 16.2 га талбайд газар чөлөөлөх ажил тусгагдсан.

Мөн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сэлбэ дэд төв орчмын хоёрдугаар ээлжийн газар чөлөөлөх ажил Сүхбаатар дүүргийн 12, 13 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 14, 15, 16, 18, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт хийгдэхээр тусгагдсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын "Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх байршил тогтоох тухай" 2024 оны 107 дугаар тогтоолоор Сүхбаатар дүүргийн 12, 13 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 14, 15, 16, 18, 22





дугаар хорооны нутаг дэвсгэрт Сэлбэ дэд төв орчмын II ээлжийн 733.0 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байршлыг тогтоож, эргэлтийн цэгийн солбилцлыг баталсан.

Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо Жаргалантын аманд Яармаг хотын шинэ төвийн 93МВт-ын дэвшилтэт технологи бүхий дулааны эх үүсвэрийн зориулалтаар 3.8 га талбай бүхий газар олгуулах асуудлыг тусгуулсан.

ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ

ЦАХИЛГААН ХАНГАМЖ:

Улаанбаатар дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгон тоноглон шинэчлэх, Парк, Дамбадаржаа, Баянхошуу, Их наран дэд станц, 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1. Дамбадаржаа, Баянхошуу, Их наран, зуслангийн чиглэлийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх 110/35/10кВ-ын 2*40МВА чадалтай дэд станц, 110кВ-ын ЦДАШ-ын газар олголтыг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороо, 1462304073 нэгж талбарын дугаартай 1,5 га талбай бүхий газрыг Дэд бүтцийн байгууллага /цахилгаан дэд станц/ зориулалтаар Нийслэлийн Засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/549 дүгээр захирамжаар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн нэр дээр олгосон ба Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж буй Дамбадаржаа дэд төв болон Дамбадаржаа, 32-ын тойрог, Зуслан чиглэлийн нийт 32,000 айл өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаар Эрчим хүчний яамны 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 23/2019/17 дугаартай техникийн нөхцөлтэй 110 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам, 2*40 МВА чадалтай 110/35/10 кВ-ын Дамбадаржаа дэд станцыг тус газарт барихаар болсон.

Шинээр барих Дамбадаржаа дэд станцад олгосон газар нь дэд станц барихад тохиромжгүй уулын налуу хэсэгт байрлаж байгаа бөгөөд барилга угсралт, ашиглалт, засвар, үйлчилгээ явуулах, 35кВ, 10кВ-ын шугамын гаргалгаа гаргах, агаарын шугамын трасс гаргах боломжгүй, дэд төвийг цахилгаан эрчим хүчээр хангахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхээр байсан.



Улаанбаатар цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ний зүгээс ажлын зураг өөрчлөлт оруулан газрын байршил өөрчлүүлэх тухай 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/72 дугаартай албан хүсэлтийг ирүүлсэн.

Энэ хүсэлтийг судлан газар олголтыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран ажиллаж байршил солихоор ирүүлсэн хүсэлтэд дурдсан газрын эзэмшигчтэй тохиролцон нөхөх олговортой газар эзэмших эрх шилжүүлэхээр болсон. 10/35/10кВ-ын Дамбадаржаа дэд станцын гүйцэтгэгчээр ДМТМ ХХК шалгарсан бөгөөд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсан. 110кВ-ын тулгуурын суурийн ажлууд хийгдэж байна.

2. Нийслэлийн төвийн хэсгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах 110/10/6 кВ-ын Парк дэд станц барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 0.12 га газрыг УСАХ-ийн хашаан дотор олгуулахаар тусгуулсан.

Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/55, А/124 дугаартай тушаал, захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан 2 удаа хуралдаж ажилласан бөгөөд 110/10/6кВ-ын Парк дэд станцын газар олголтыг “MN централ оффис”-ын барилгын урд байршилд сонгосон.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 25/48 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвийн хэсгийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах зорилгоор Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн 10.2 га талбайд

цахилгааны дэд станц өргөтгөн барихтай холбогдуулан Эрчим хүчний яамны харьяа “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн эзэмшиж буй 0.089 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж 0.12 га хэмжээтэйгээр төлөвлөсөн байршилд шилжүүлэхийг зөвшөөрсөн.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн Газар эзэмших эрх олгох тухай А/698 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Эрчим хүч дамжуулах станцын зориулалтаар 1200 м.кв газрыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д олгох шийдвэр гарсан.

Дэд станцын 110кВ-ын кабель шугамын трассыг Бохир усны Туул коллекторын трасстай уялдуулж шийдэл гаргахаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК болон зураг төсөл зохиогч Бодит чадал ХХК судалгаа хийж байна.





ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ХҮРЭЭНД

Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах төлөвлөлтийн хүрээнд 2027 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төслүүдийн мэдээллийг Эрчим хүчний яам, Хот байгуулалт хотын стандартын газар, Улаанбаатар дулааны үндэсний сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК хамтран боловсруулж ажлын хэсгийн 2 дугаар хуралд танилцуулсан.

тус ажлын хүрээнд 2025 он, 2026-2027 оны хооронд хэрэгжүүлэх боломжтой 26 төслөөс эхний ээлжийн 13 байршилд газар чөлөөлөх асуудлыг судлуулахаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-аас Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хандаад байна.

Үүнээс газар олголтын асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай 9 байршлыг Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд оруулан шийдвэрлүүлэх саналыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд Нийслэлийн Ерөнхий Архитекторын 2025 оны 03/15 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Мөн нийслэлийн хэмжээнд 21 байршилд хийгдэхээр төлөвлөж буй дэд станц, шугам сүлжээний ажлын байршил, газар олголтыг шийдвэрлүүлэхээр нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд 2025 оны 01/1165 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.

ДУЛААН ХАНГАМЖ:

Дулаан хангамжийн гол болон орон сууцны хорооллын төвлөрсөн шугам сүлжээ, насос станцыг өргөтгөн шинэчилж, шинээр барьж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

➢ Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Да хүрээ гудамж, Доржийн гудамж дагуу хийгдэхээр төлөвлөж байгаа дулааны магистраль шугамын трасс дагуу хээрийн судалгааг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтэс, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн инженерийн хамт 2025.03.14-ний өдөр хийсэн.

Төв магистраль шугам хийгдэхээр төлөвлөж байгаа тул трасс дагуу явж гудамж, замын өргөн, өндөржилтийн байдлыг тандан судалсан.

Уг шугамыг УДБС ТӨХК-ийн ирүүлсэн саналын дагуу *“Амгалан дулааны станц – Эрдэнэтолгойн-40 гудамж – Хилчний гудамж – Да хүрээ гудамж – Б.Доржийн гудамж”* дагуу Цайз захаас Шар хад хүртэл төв замын өргөтгөлийн ажилтай уялдуулан 1 дүгээр

эгнээний зам дагуу тунелийн системээр хийх боломжтой гэж үзэн холбогдох судалгаа, эдийн засгийн тооцоо гарган ажиллахаар болсон. Энэхүү дулааны шугам хийгдсэнээр “Шар хад”, “Эрдэнэтолгой”, “Монел”-ийн хэрэглэгчид зэрэг Улаанбаатар хотын хойд хэсгийн хэрэглэгчид төвийн төвлөрсөн дулааны системд холбогдох, ТЭЦ-3, ТЭЦ-4 станцын ачаалал буурах юм.

Амгалан дулааны станцын өргөтгөл хийгдсэнээр Улаанбаатар хотын хойд хэсгийн хэрэглэгчдийг хэрэглээний дулаан эрчим хүчээр хангах хүчин чадал нэмэгдэх бөгөөд энэ хүрээнд Доржийн гудамж дагуу хийгдэх дулааны шугамын трассыг Шар хад-Цайз захын замын өргөтгөл, шинэтгэлийн хүрээнд одоо байгаа 4 эгнээ замыг 6 эгнээ болгох ажлын хүрээнд хийгдсэн замын зураг төсөлтэй уялдуулан замын 1-р эгнээгээр хийхээр төлөвлөн Хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан.



- Дулааны шугамын өөрчлөлт, шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд
- Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Магистраль шугамын ажилд газар чөлөөлөх
- Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Мөсөн гулгуурын зүүн урд талд Дулааны шугамын зориулалтаар газар чөлөөлөхөөр
- Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо Зайсан орчимд Магистраль шугамын ажилд газар чөлөөлөх
- Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо Нисэх орчимд Магистраль шугамын ажилд газар чөлөөлөх
- Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороонд Магистраль шугамын ажилд газар чөлөөлөхөөр нийт 5 байршилд санал тусгуулсан.

Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд шинээр дулааны эх үүсвэр барих 3 байршлын газар олголтын асуудлыг тусгуулахаар Нийслэлийн Ерөнхий Архитекторын 2025 оны 03/15 дугаар албан бичгээр хүргүүлсэн.



Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Магистраль шугамын шинэчлэлийн ажил

ХИЙН ХАНГАМЖ:



Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 24/26 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Дулааны эх үүсвэр барих” зориулалтаар 3.8 га газар олгохоор тусгагдсан.

Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ажлын зураг төслийг зөвшилцсөн бөгөөд хотын мэдээллийн санд оруулсан.

2025-2028 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдэд шаардлагатай 93ВМт-ын Дэнжийн мянга дулааны станц төлөвлөгдсөн. 2025 оны 03 дугаар сарын 21-нд НГЗБА-нд нийт нөлөөлөлд өртсөн өртсөн 84 нэгж талбараар чөлөөлөгдөөгүй 11 нэгж талбарыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн.

Тус эх үүсвэрийн байршил нь 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан.

Хот байгуулалтын асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар нийслэлийн нутаг дэвсгэрийн 8 байршилд хийгдэх хийн дулаанаар хангагдах дулааны эх үүсвэр танилцуулагдан дэмжигдэж Инженерийн дэд бүтэц төлөвлөх даалгавар гарсан.

Үүнд:

- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 3 байршилд
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 1 байршилд
- Нийслэлийн ерөнхий боловсролын дөчин есдүгээр сургууль
- Нийслэлийн ерөнхий боловсролын далан хоёрдугаар сургууль
- Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК
- Эмээлт эко аж үйлдвэрийн парк зэрэг байршлуудад хийн эх үүсвэрээр хангагдах дулааны эх үүсвэрийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар гарсан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт хатуу түлш хэрэглэхийг хориглосон “Ногоон бүс” тогтоон бүсчлэлийн хил заагийг тогтоох, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК ногоон бүс дотор цахилгаан эрчим хүчээр халаах боломжтой 10,000 айлыг байршлаар тогтоон хүчин чадлыг тооцоолж гаргахаар болсон ба хий болон цахилгаан, хосолмол эх үүсвэрээс дулаан хангамжийг шийдвэрлэхээр ажиллаж байна.



ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ:

- Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх хүрээнд 9 байршилд үерийн хамгаалалтын суваг, Инженерийн шугам сүлжээ зориулалтаар хийгдэх ажил тусгуулан батлуулсан.
- Инженерийн бэлтгэл арга хэмжээний хүрээнд Хот төлөвлөлийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 9 удаагийн хурлаар 20 байршилд хийгдэх ажлын зургийн даалгавар танилцуулагдан дэмжигдэж, даалгавар батлагдан захиалагч нарт хүргүүлэн ажилласан.

○ Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн 15, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хөрсний ус, үерийн ус зайлуулах сувгийн ажлын зураг, төсөв хийхээр төлөвлөж 4 байршилд ажлын даалгавар гаргуулах хүсэлт ирүүлсний дагуу газар олголт, хот байгуулалтын судалгааг хийн даалгавар гаргуулахаар Инженерийн бэлтгэл арга хэмжээ хариуцсан мэргэжилтэнд шилжүүлэн ажилласан.

Сүхбаатар дүүрэг, Хөрсний ус, үерийн ус зайлуулах сувгийн ажил хийхээр төлөвлөж байгаа 4 байршил









УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА:

Ус хангамжийн , ариутгах татуургын ажлын хүрээнд Дагуул хот, гэр хорооллын бүсэд хэсэгчилсэн цэвэрлэх байгууламж, шугам сүлжээг барьж, Туул-1, Толгойт, Орбит, Цайз зэрэг коллекторуудыг ашиглалтад оруулж, Улаанбаатар хотын Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлэх ажил төлөвлөгөөнд тусгагдсан.

Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын Ажил эрчимжүүлэх тухай А/62 дугаар тушаалын дагуу хот байгуулалтын цахим систем e_barilga удирдлагын системд ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний зөвшилцсөн зурган мэдээллийг байршуулж ажилласан.Энэ хүрээнд 25 байршилд гадна цэвэр ус, ариутгах татуургын шугамын мэдээллийг оруулж ажилласан байна.

Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 6 байршилд Тохируулах усан сан, цэвэрлэх байгууламжийн гаргалгааны шугам, Цэвэр усны шугамын зориулалтаар газар чөлөөлөхөөр тусгуулсан бол 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд 3 байршил нэмж оруулан НИТХ-аар хэлэлцүүлэн дэмжигдэж батлуулахад бэлэн болоод байна.

Усан сан: /Төлөвлөгөөний тодотголд хүргүүлсэн санал/

№	Дүүрэг хороо	Газрын байршил	Зориулалт	Газры хэмжээ /га/	Төлөвлөлтийн нэгж талбар	Хугацаа	Хариуцах байгууллага	Тайлбар
1	Чингэлтэй дүүрэг 14 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Хайлааст усан сангийн өргөтгөл 1000м3	1.0		I-IY улиралд	УСУГ ХБХСГ,	Одоо байгаа усан санг өргөтгөж хүчин чадал нэмнэ. Зураг төслийн төсөв батлагдсан
2	Чингэлтэй дүүрэг 14 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Технологийн усны усан сан 1000м3	1.0		I-IY улиралд	УСУГ ХБХСГ,	Газар олголтгүй газар төлөвлөсөн. Зураг төслийн төсөв батлагдсан
3	Баянзүрх дүүрэг 11 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Хүрэл тогоотын ам усан сан	1.0		I-IY улиралд	УСУГ ХБХСГ,	Богдхан ДЦГ ТХГН Инвескор ХХК Хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ.

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨХ:

Нийслэлийн Ерөнхий Архитектор, Хот байгуулалт, хотын стандартын газар 2025 онд 134 байршилд авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлагдсан.

Үүнд:

- 121 байршилд 233479 у/м Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар,
- 8 байршилд 52090 м2 талбайд Гүүрэн байгууламж төлөвлөх даалгавар
- 4 байршилд 11680 у/м Явган болон дугуйн зам төлөвлөх даалгавар,
- 1 байршилд 4200 у/м Дүүжин тээврийн замын даалгавар тус тус батлагдан "Хот байгуулалтын мэдээллийн сан"-д байршуулсан.





Мөн

- Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Солонго хороолол орчмын авто замын сүлжээний зургийн даалгавар боловсруулах
- Нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжих "Нийтийн эзэмшлийн явган хүний зам, дугуйн замын зураг төсөл боловсруулах даалгавар,
- Улаанбаатар хотын авто зогсоолын менежментийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл боловсруулах" техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг боловсруулах ажлын даалгавар,
- Эмээлт аж үйлдвэрийгн парк
- СОР-17 ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах даалгавар,
- Агро сити аж үйлдвэрийн паркийн ТЭЗҮ, зургийн даалгавар боловсруулах,

Инженерийн бэлтгэл арга хэмжээний хүрээнд Хот төлөвлөлийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 9 удаагийн хурлаар 20 байршилд хийгдэх ажлын зургын даалгавар танилцуулагдан дэмжигдэж, даалгавар батлагдан захиалагч нарт хүргүүлэн ажилласан.

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗАГВАР ЗУРАГ

Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх авто зам, замын байгууламжийн 35 загвар зураг батлагдсан байна.

Үүнд:

1. *БЗД, Нарантуулын уулзварын өргөтгөл*
2. *ХУД, 21-р хороо, Шүүх шинжилгээний ерөнхий газрын эмнэлгийн авто зам, зогсоол*
3. *БЗД, Нарантуул нүхэн гарцын зураг төсөл*
4. *ХУД, 16-р хороо, хороолол дундах авто зам*
5. *БГД, 20-р хороо, 5-н шарын гуурэн гарц*
6. *ХУД, 13-р хороо, 7 хэсгийн гэр хорооллын авто зам,*
7. *ХУД, 16-р хороо, Буянт-Ухаа 6-р гудамжны авто зам*
8. *СХД, сансар 7-р гудамжны авто зам*
9. *СХД, 10-р хороо, Жишиг эрдэм сургуулийн авто зам*
10. *ХУД, Буянт-Ухаа цогцолборын замын байгууламж*
11. *ХУД, Яармаг шинэ төвийн гол гудамж зам*
12. *НД, 3-р хороо, Плэйтайм аялал жуулчлалын цогцолбор газар хүртэлх авто зам*
13. *ХУД, 8-р хороо, Архивчдын гудамжнаас нүхтийн ам хүрэх авто зам*
14. *БЗД, 21-р хороо, Цагаан даваа-ландфилийн талбай хүрэх авто зам*
15. *Туулын хурдны зам*
16. *СХД, Тахилтын замаас Дарханы замтай холбох шинээр баригдах авто зам*
17. *ХУД, 12-р хороо, хорооллын зам*
18. *Трам төслийн танилцуулга*
19. *ХУД, 21-р хороо, 161-р сургууль орчмын авто зам*
20. *ХУД, 21-р хороо, Морингййн даваа, гэр хорооллыг авто зам*
21. *Нэгдүгээр тойрог зам*
22. *5 Шарын явган хүний гүүрэн гарц*
23. *ХУД.14-р хороо Ар хөндлөнгийн ам зуслангийн авто зам*
24. *ХУД, 27-Р НЭГЖ ХОРООЛОЛ*
25. *ХУД, Нисэхийн шинэ эцэс хүртэлх*
26. *ХУД, 342-р худаг хүртэлх*
27. *ХУД, Сонсголонгийн зам хүртэлх*
28. *ХУД, Сөүл гарден хүртэлх*
29. *ХУД, 14-р хорооны зүүн талын зам*
30. *ХУД, Өлзийтийн 22-р гудамж хүртэлх зам*
31. *НД, Их амны зургийн танилцуулга Максимал ХХК*
32. *СБД,16 дугаар хороо, Бэлхийн 33-5 дугаар гудамжинд хийгдэх авто зам*
33. *БЗД 11-р хороо, Эко рэстор натур ХХК*
34. *БЗД 11-р хороо, Эко рэстор натур ХХК*
35. *Л.Энэбишийн гудамжны дахин төлөвлөлт, /олон төрөлт тээврийн хэрэгсэл BRT/*





Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах, зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “ЗОГСООЛ НЭГДСЭН ХӨТӨЛБӨР” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тухайн ажлын хэсгийн тайланг хэлтсийн даргын хамт нэгтгэж танилцуулга бэлтгэн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн хорооны засаг дарга нартай хийсэн уулзалтаар өгсөн үүрэг, даалгаврын дагуу дүүргүүдээс далд зогсоол болон олон төрөлт (ил, далд, давхар) зогсоол төлөвлөх боломжтой нийт 120 байршилд 288076 м2 талбайд 10288 автомашины багтаамжтай зогсоол төлөвлөх саналаа албан бичгээр ирүүлсэн.

Үүнд:

№	Дүүрэг	Байршлын тоо	Тайлбар
1	Баянгол	37	2025.04.15-ны 01/896 тоот албан бичиг
2	Баянзүрх	10	2025.04.28-ны 02/1006 тоот албан бичиг
3	Хан-Уул	20	2025.04.15-ны 03/536 тоот албан бичиг
4	Сүхбаатар	4	2025.04.14-ний 09/848 тоот албан бичиг
5	Сонгинохайрхан	12	2025.04.15-ны 03/1076 тоот албан бичиг
6	Чингэлтэй	34	2025.04.29-ний 03/1202 тоот албан бичиг
7	Багануур	3	2025.04.16-ны 03/371 тоот албан бичиг
	НИЙТ	120	

Үүнээс Чингэлтэй, Баянгол дүүрэгт 1000м2-аас дээш талбайтай байршлыг, бусад дүүрэгт 1500м2 ба түүнээс дээш талбайтай байршлын саналыг судалгаанд оруулсан. Ерөнхий Архитектор танилцуулга материалыг бэлтгэн хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/1210 дугаартай захирамж гарч нийслэлийн нутаг дэвсгэрт

- 30 байрлалд авто зогсоолын ТЭЗҮ,
- 20 байрлалд барилга байгууламжийн урьдчилсан судалгаа, төлөвлөлт боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, уг арга хэмжээний худалдан авах арга хэмжээ зохиохыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж үр дүнг танилцуулахыг даалгасан.

“Улаанбаатар хотын авто зогсоолын менежментийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл боловсруулах” хөтөлбөр болон техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг боловсруулах ажлын даалгавар гарч 2025 оны 02/374 тоот албан бичгээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.

➢ Авто машины зогсоол төлөвлөх судалгааны хүрээнд 4 байршлын газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээний судалгааг гарган өгч ажилласан.









➢ *Нийслэлийн нутаг дэвсгэр дэх "Авто машины зогсоолын хүртээмж"-ийн талаар Цахим судалгааг "Google forms" платформоор 2025.02.03-2025.02.18-ны өдрүүдэд авч дүнг нэгтгэн гаргасан.*





Уг судалгааг нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэдээс авсан. Судалгаа нь 8 асуумжтай байсан.

Эдгээр нь:

1. Таны орчинд авто зогсоол хүртээмжтэй байна уу.
2. Таны орчинд ямар төрлийн авто зогсоол шаардлагатай байна вэ.
3. Таны орчинд нийтийн зам талбайд авто зогсоол бий болговол дэмжих үү.
4. Дулаан зогсоолтой болсноор нийтийн тээврийн хэрэгслийг сонгох боломж бий болох уу.
5. Авто зогсоолын барилга угсралтын ажлыг улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийхийг зөвшөөрөх үү.
6. Авто зогсоол төлбөртэй байх нь зөв үү.
7. Та сард дулаан зогсоолд хэдэн төгрөг төлдөг вэ.
8. Төлбөртэй бол өдөрт хэдэн төгрөгийг төлөх боломжтой вэ.



Судалгаанд **3944** иргэн хамрагдсан ба дүүргээр нь авч үзвэл

№	Дүүрэг	Хамрагдсан иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Баянгол	710	18%
2	Баянзүрх	1432	36%
3	Хан-Уул	624	16%
4	Сүхбаатар	16	0,2%
5	Сонгинохайрхан	848	22%
6	Чингэлтэй	302	8%
	НИЙТ	**3944**	**100%**



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ:

*Судалгаанд хамрагдсан – **3944** иргэн.*

- **Зогсоолын хүртээмж: - 3891 иргэн хариулсан.**

- 3560 иргэн буюу **91%** нь **"Зогсоол хүртээмжгүй"**,

- **Төлбөртэй зогсоол байгуулбал:**

- Иргэдийн **64%** нь **"Төлбөртэй зогсоолыг дэмжихгүй"** байна.

- **Төлбөрийн хэмжээ:**

- Иргэдийн **96%** нь Төлбөртэй бол сард **10,000₮** төлөх боломжтой гэж хариулсан.

1. Цаашид барилга байгууламж төлөвлөхдөө өрх болон авто машины зогсоолыг **"1:1"** буюу **"1 өрх - 1 зогсоол"** харьцаагаар төлөвлөх.
2. Бага орон зайд олон авто машины зогсоол төлөвлөх шийдлийг сонгох
3. Төлбөртэй зогсоол хийхээр бол иргэдийн төлбөрийн чадварыг харгалзан үзэх
4. Ипотек, ногоон зээл, нөхөн олговор зэрэг төр, хувийн хэвшлээс дэмжлэгээр зогсоолтой болох боломжийг бүрдүүлэх.

Судалгаанаас үзэхэд иргэд зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

ХУУЛИАР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

1. 2025 онд хийж гүйцэтгэх ажлын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна.
2. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, erp системийн ашиглалтыг сайжруулж зөрчилгүй ажиллаж байна.

Ирсэн албан бичиг 70.

Шийдвэрлэлтийн дундаж хоног – **6** хоног

- Шийдвэрлэсэн – 70
- Судалж байгаа – 0

Ирсэн өргөдөл – 6.

Шийдвэрлэлтийн дундаж хоног – **4** хоног

- Шийдвэрлэсэн – 6
- Судалж байгаа – 0

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх ажлын хүрээнд 2 боть баримтыг архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/10 дугаар Хэрэглэгчийн үнэлгээ хийх судалгааны баг байгуулах тухай тушаалаар байгуулагдсан Хэрэглэгчийн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнд сонсогдсон.

Хэрэглэгчийн үнэлгээ хийх баг 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан, судалгааны дүнг нэгтгэх хэсэгт хуваарилагдан ажиллаж байна.

Үйлчлүүлэгчдээс авах “Сэтгэл ханамжийн цахим судалгаа”-ны асуулгыг боловсруулахад оролцсон. Энэ судалгаа нь QR code уншуулан аль болох мэргэжлийн асуулт тавихаас зайлсхийн, бага хугацаанд хурдан хариулахаар 8 асуулгатай байхаар боловсруулагдсан.

МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

- Төрийн албанаас зохион байгуулсан сургалтад тухай бүр хамрагдсан.

- Дэлхийн банк, “Тогтвортой зам тээвэр” төслийн нэгжээс зохион байгуулсан чадавхыг нэмэгдүүлэх “Дугуйн замын төлөвлөлт” сэдэвт 16 цагийн сургалтад хамрагдсан.

НҮБ-ын ХАБИТАТ төсөл, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга архитектурын сургууль, Монголын барилгын инженерүүдийн холбоо, БНХАУ-ын профессор, инженерүүдийг урьж зохион байгуулсан “Үерийн хамгаалалтын ногоон дэд бүтэц, тогтвортой ус зайлуулах систем” сэдэвт 18 цагийн сургалтад 2025 оны 11-р сарын 1-ний өдрөөс 11-р сарын 04-ны өдрүүдэд хамрагдсан.

БУСАД АЖИЛ:

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/64 дугаар албан бичгээр Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээний

- Газар олголт, ашиглалтын одоогийн байдал,
- Барилга байгууламжийн мэдээлэл
- Газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын Газрын мэдээллийн сангийн одоогийн байдлын мэдээллийг
  - *өмчлөгч,*
  - *эзэмшигч,*
  - *ашиглагчийн нэр,*
  - *хүчинтэй хугацаа,*
  - *зөрчилтэй эсэхийг* газарзүйн мэдээллийн системийн *(*shp)* өргөтгөлтэй ирүүлэх тухай хүсэлтийг хүргүүлж 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авч Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэст хүргүүлэн
- **"Хот байгуулалтын мэдээллийн менежментийн сан"**-д баяжилт хийн ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгах зохион байгуулах тухай" 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/33 дугаар захирамжийн хүрээнд гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад

- *Пийшин зуухны галлагааны аюулгүй байдал,*
- *Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа,*
- *Агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэх,*
- *"Түүхий нүүрс ашиглах тусгай зөвшөөрөл"*-тэй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт зохион байгуулан, судалгаа гаргах, зөвлөгөө зөвлөмж хүргэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ны өдрүүдэд зохион байгуулж Баянзүрх дүүргийн 31 дүгээр хорооны нутаг дэвсгэр
  - *Монел – 4,*
  - *Монел – 11,*
  - *Монел – 12,*
  - *Уулын – 10, 12 дугаар хэсгийн* 240 айл өрхөөс судалгаа авч ажилласан.

Судалгаанд Хэсгийн ахлагч Жаргал, нийслэлийн Онцгой байдлын албан хаагч, хэсгийн цагдаа нарын хамт оролцсон.

ТАНИЛЦСАН:
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД
БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА (Ц.ЛХАМСҮРЭН)

ТАЙЛАН БИЧСЭН:
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ
ЗУРАГЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН (О.БАТТУЛГА)